



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.07.10 № 1257  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
НИЙСЛЭЛИЙН МОНГОЛ АРДЫН  
НАМЫН ХОРООНД

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Нийслэлийн Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Нийслэлийн Монгол Ардын намын хорооны Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн


37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Нийслэлийн Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр 1/3 хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Нийслэлийн Сонгуулийн хороонд

Хавсралт 1/3... хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР



# НИЙСЛЭЛИЙН ИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД НИЙСЛЭЛИЙН МАН-ЫН ХОРООНООС ДЭВШҮҮЛЖ ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

## Хөрөнгө оруулалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн хот

**ШИЙДЭЛ 1.** Хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлж, төсөв санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ

1. Нийслэлийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, хотын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
2. Нийслэлийн хөрөнгө оруулалтын сан байгуулж, гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
3. Нийслэлийн үнэт цаас гаргаж, санхүү, хөрөнгө оруулалтын чадавхыг дээшлүүлэн, нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэнэ.
4. Хөрөнгө оруулалтын ханган нийлүүлэлтийн хөтөлбөр боловсруулж, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээнэ.
5. Хотын төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг танах, хэмнэлтийн горимд шилжүүлж төсвийн алдагдлыг бууруулж, бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох замаар үр ашгийг нэмэгдүүлнэ.
6. Нийслэлийн төсөв, санхүүгийн эрх мэдлийг нэмэгдүүлж, эдийн засгийн хувьд бие даасан байдлыг бий болгоно.
7. Хотын дэд бүтэц, эрчим хүч, авто замын томоохон төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, Шинэ Зуунмод хот, Майдар хот байгуулалтын ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
8. Хөшигийн хөндийд хотын эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлнэ.
9. Шинэ хотуудыг хөгжүүлэх замаар Улаанбаатар хотын эдийн засгийн бие даасан байдлыг бий болгох ажлыг эрчимжүүлнэ:
  - Эмээлтийн "Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк"
  - "Улаанбаатар хотын ачаа тээврийн нэгдсэн логистикийн төв"
  - Багахангай дүүрэгт "Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк"
  - Багануурын үйлдвэр, технологийн парк
  - Налайхын барилгын материал, үйлдвэрлэл, технологийн парк
10. Хотын бүсчлэлийн дүрмийг батлуулан мөрдүүлж бүс тус бүрд нийцсэн газар ашиглалт, барилгажилтын тусгайлсан бодлого хэрэгжүүлнэ.
11. Бизнес тээлтэй эрх зүйн орчин бүрдүүлэх хүрээнд аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны зөвшөөрлийн тоог цөөрүүлж, зөвшөөрөл олгох нөхцөл журмыг тодорхой, ойлгомжтой болгож, хяналт шалгалтыг цөөрүүлнэ.

**ШИЙДЭЛ 2.** Эдийн засгийн хямралыг даван туулна.

12. Хотын иргэд, аж ахуйн нэгжийн өрийн дарамтыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авч, иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжин орлогыг нэмэгдүүлэх нөхцлийг хангана.
13. Жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгчдэд бага хүүтэй зээлд хамрагдах нөхцлийг хангана.
14. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, эмзэг байдлыг бууруулах, эрсдэлийг багасгах чиглэлээр олон улсын болон бүс нутгийн банк, санхүүгийн байгууллагуудтай нягт хамтран ажиллана.

15. Эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн нийгмийн хамгааллын зорилтот арга хэмжээ хэрэгжүүлнэ.

**ШИЙДЭЛ 3. Нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засгийн суурийг тавьж, хүнсний аюулгүй байдлыг бүрэн хангана.**

16. Хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй, үр ашигтай, дэвшилтэт технологи нэвтрүүлж, нөөцийг хэмнэх, эргүүлэн ашиглах, хаягдлыг дахин боловсруулж ашиглах тойргийн /циркуляр/ эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлнэ.
17. Импортын худалдаа, бэлтгэн нийлүүлэлт, үйлдвэр аж ахуйн нэгжүүд, жижиглэн худалдааны сүлжээг хамарсан үйлдвэрлэгч, импортлогч сав баглаа боодлыг эргүүлэн худалдан авах, хог хаягдлыг дахин ашиглах тогтолцоог бүрдүүлнэ.
18. Хуванцар сав, шил, лааз хоёрдогч түүхий эд худалдан авах сүлжээг бий болгоно.
19. Дотоодын хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж, сүү, сүүн бүтээгдэхүүн, тахиа, гахай, зөгий, загасны аж ахуй зэрэг дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн, бүтээгдэхүүний нийлүүлэлт, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
20. Жимс жимсгэний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, чацарганы үйлдвэрлэлийн нэгдсэн сүлжээ байгуулан, хотын хүн амыг амин дэм бүхий жимс жимсгэнээр хангах нөхцлийг бүрдүүлнэ.
21. Өвөл, зуны хүлэмжийн загвар, цогцолбор аж ахуйг хөгжүүлж, хот суурингийн хүн амыг шинэ ургацын ногоогоор тогтвортой хангахад чиглэсэн арга хэмжээ авна.
22. Хүнсний хяналт-шинжилгээний сүлжээг бий болгон олон улсын стандартад нийцсэн хүнсний лаборатори байгуулж, хүнсний аюулгүй байдлын бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим санг бий болгоно.
23. Сонгинохайрхан, Баянзүрх, Налайх, Багахангай дүүрэгт Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, мах махан бүтээгдэхүүний хадгалалт борлуулалтын цогцолбор төвүүдийг барьж байгуулан ашиглалтад оруулж, хотыг эрүүл, аюулгүй хүнсээр найдвартай хангах тогтолцоог бүрдүүлнэ.
24. Хотын үйлчилгээнд тохирсон орчин үеийн дэвшилтэт технологи бүхий бага, дунд оврын хүнсний боловсруулах жишиг загвар үйлдвэрийг байгуулахыг дэмжинэ.
25. Хотын гарц бүрийг төрөлжүүлэн хөгжүүлж, захын дүүрэгт аж үйлдвэрлэлийг төвлөрүүлж, үйлдвэрүүдийн хамтын ажиллагааг дэмжин, кластерыг бүртгэлжүүлэн бодлогоор дэмжинэ.

**ШИЙДЭЛ 4. Хотыг шинжлэх ухаан, технологийн төв, өндөр технологийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, үйлчилгээний бүс болгон хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.**


26. Хотыг шинжлэх ухаан, технологи, инновацын төв болгон хөгжүүлэх бодлогыг тууштай үргэлжлүүлэн, инновац, гарааны бизнес, оюуны үйлдвэрлэлийг хөгжүүлж, экспортыг нэмэгдүүлнэ.
27. Шинэ технологи бүтээж, амжилттай нэвтрүүлсэн төрийн болон хувийн аж ауйн нэгжийн судалгаа хөгжүүлэлтэд гаргасан зардлыг бүтэн болон тодорхой хувиар буцаан олгох, нэвтрүүлсэн хувийн аж ахуйн нэгжүүдийг урамшуулах механизм бий болгоно.
28. Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарт олон улсын жишигт нийцсэн барилга, байгууламж, лабораторийн орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгохыг дэмжинэ.
29. Хувийн хэвшлийн оролцоонд тулгуурласан Хамтын хөрөнгө оруулалтын санг байгуулж, инновацын төсөл арга хэмжээг санхүүжүүлэх тааламжтай бүтцийг бүрдүүлнэ.



30. Нээлттэй лабораторид суурилсан био, нанотехнологийг хөгжүүлж, оюуны багтаамж өндөртэй, экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлнэ.
31. “Монгол контент” бүтээгчдийг үргэлжлүүлэн дэмжих бодлого баримтална.
32. Япон, Солонгос, хөрш орнууд, Төв Ази, Турк, Европ, Америкийн аялал жуучлалын томоохон компаниудтай хамтран төрөлжсөн аялал жуучлал хөгжүүлж, хотын аялал жуучлалын хөтөлбөр хэрэгжүүлнэ.
33. Гадаад, дотоодын жуулчид Улаанбаатар хотод аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
34. Жуулчны гудамжны үйл ажиллагааны идэвхжүүлж гадаад дотоодын жуулчдын зорих газрын тоог нэмэгдүүлнэ.

#### ШИЙДЭЛ 5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн эдийн засгийн бодлого хэрэгжүүлнэ

35. Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих хотын худалдааны сүлжээг бий болгон, ажлын байрны шингээлт ихтэй эдийн засгийн салбарыг дэмжиж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
36. Улаанбаатар хот, шинэ хот, тосгон, суурин газрын ажилгүй иргэнийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, байгууллагад эдийн засгийн болон санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.
37. Хүнсний үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх загвар төслүүдийг дүүргийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
38. Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх загвар төслүүдийг дүүргийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
39. Улаанбаатар хот, шинэ хот, тосгон, суурин газрын нөхөрлөл, хоршоо, иргэд гэр бүлээрээ ба хувиараа бизнес эрхлэхийг санхүүгийн болон зах зээлтэй холбох, өртгийн сүлжээний кластер байгуулах төслүүдийг улс, аймгийн бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээнд холбох ажлыг зохион байгуулна.
40. Нийслэлийн өмчийн хадгалалт, борлуулалтын цогцолбор байгуулж жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ.
41. Төрийн нийгмийн хариуцлагын хүрээнд өрхийн аж ахуй, нөхөрлөл, хоршоо, үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг төрийн худалдан авалтаар дэмжих, төрийн үйлчилгээний болон хот нийтийн аж ахуйн ажилд ажилгүй, бага орлоготой, ядуурлын түвшнээс доогуур хэрэглээтэй өрхийн гишүүдийг хамруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
42. Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд аж ахуйн нэгжүүд ажилгүй, бага орлоготой, ядуурлын түвшнээс доогуур хэрэглээтэй өрхийн гишүүнийг ажлын байраар хангаж ажилчдын цалин урамшууллыг өрхийн амьжиргааг хангах түвшинд хүргэх нөхцлийг хангана.
43. Ажлаас халагдсан, ажил хайж байгаа иргэдийг давтан сургаж, дадлагажуулан ажлын байраар хангахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
44. “Ахмадын зөвлөх үйлчилгээ”-гээр хүүхэд, залууст ажлын дадлага, туршлага, мэргэжлийн ур чадварыг нь өвлүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.
45. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сурах, хөгжих үйлчилгээ үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлнэ.



## Хотын сайн засаглал


ШИЙДЭЛ 1. Иргэндээ нээлттэй, чирэгдэлгүй, тасралтгүй, үр дүнтэй хотын үйлчилгээг үзүүлдэг ухаалаг, аюулгүй хотыг бий болгоно.

46. Хот төлөвлөлтийн бодлогыг оновчтой хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх эрх зүйн шинэчлэл хийнэ.
47. Нийслэлийн төсөв, татвартай холбоотой эрх мэдлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлнэ.
48. Хотын төсөв, санхүүгийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор Нийслэл хотын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.
49. Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээний худалдан авах үйл ажиллагаа, түүний санхүүжилтыг олон шат дамжлагагүй, үр дүнтэй зохион байгуулах эрх зүйн орчин, захиргааны соёл, хариуцлагын тогтолцоог бүрэн төлөвшүүлнэ.
50. Нийслэлийн дүүргүүдээс олгодог хоол, худалдаа, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлж, мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан түргэн шуурхай, чирэгдэлгүй шийдвэрлэдэг болно.
51. “Нэг хот – нэг стандарт”-ыг бүрэн хэвшүүлнэ.
52. “Нэг иргэн – нэг бүртгэл хөтөлбөр”-ийг эрчимжүүлж, иргэдээс нэг л удаа мэдээлэл авдаг тогтолцоонд шилжих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
53. Нийслэлийн Нэгдсэн сүлжээ, цахим хуудасны аюулгүй байдлыг сайжруулж, мэдээллийн нууцлалыг хангаж ажиллана.
54. Цахим бизнес, онлайн, зайн хөдөлмөр эрхлэлтийг бодлогоор дэмжинэ.
55. Улаанбаатар хотын цахим ой санамж болох мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн бүтэн байдал, нэгдмэл аюулгүй байдлыг хангаж, нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгоно.
56. Улаанбаатар хотын газарзүйн мэдээллийн системд тулгуурласан хаягжилтын нэгдсэн сан бүрдүүлж, иргэд, байгууллагын хэрэглээнд нэвтрүүлнэ.
57. Орон зайн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлж, нийслэлийн шийдвэр гаргах бүх түвшинд ашиглах ажлыг авч хэрэгжүүлнэ.
58. Нийслэлийн төрийн захиргаа, харьяа байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар иргэд цахим хэлбэрээр саналаа чөлөөтэй илэрхийлэх, цахим хэлэлцүүлгийн технологийг хөгжүүлнэ.
59. “Нэг тархи нэгдсэн систем”-ийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.
60. Нийслэл, дүүргийн төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгана.
61. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.

## Түгжрэлгүй хот

ШИЙДЭЛ 1. Олон төрөлт, орчин үеийн ухаалаг тээврийн сүлжээг бий болгоно.

62. Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлтийг олон улсын стандартад нийцүүлэн хийж гүйцэтгэнэ.
63. BRT систем зэрэг багтаамж ихтэй зорчигч тээврийн төрлийг нэвтрүүлнэ.
64. Агаарын дүүжин замын тээврийн төсөл хэрэгжүүлж, зориулалтын зогсоол, дэд бүтцийг барьж байгуулна.
65. Таван шараас Офицеруудын ордон хүртэлх цахилгаан соронзон тээврийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.
66. Сургуулийн хүүхдэд зориулсан тээврийн хүчин чадал, үйлчилгээний хүрээг өргөтгөн, шинэ менежмент нэвтрүүлнэ.



67. Төр, хувийн хэвшлийн хамтын түншлэлийн хүрээнд хотын такси тээврийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.
68. Шинэ хотуудыг холбосон багтаамж ихтэй нийтийн тээврийг нэвтрүүлнэ.
69. Зорчигч тээврийн үйлчилгээний дамжин суулт хийх нэгдсэн терминал, зогсоолуудыг барьж байгуулна.
70. Тээврийн хэрэгслийг цахилгаан болон хийн эх үүсвэрээр цэнэглэх сүлжээг өргөтгөнө.

#### ШИЙДЭЛ 2. Гудамж замын даан, нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлнэ.

71. Улаанбаатар хотын авто замын мастер төлөвлөгөөг баталж үе шаттай хэрэгжүүлнэ.
72. Хотын авто замын сүлжээг өргөтгөн сайжруулах, шинэ суурьшлын бүс болон гэр хорооллын гол гудамж замыг өргөтгөн, хатуу хучилттай, явган замтай болгох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
73. Одоо байгаа хатуу хучилттай авто замыг шинэчилж, өргөтгөнө.
74. Хөдөлгөөний нягтрал ихтэй байршилд явган хүнд зориулсан гүүрэн болон нүхэн гарц байгуулна.
75. Давхар зогсоолын тоог нэмэгдүүлж, авто зогсоолын менежментийн боловсронгуй тогтолцоог бий болгоно.
76. Хотын гол болон туслах гудамж замын уулзвар, төмөр замын гарам дээгүүр гүүрэн гарц барих ажлыг эхлүүлнэ.
77. Авто тээврийн товчоодын байршлыг оновчтой болгож, зорчигч тээврийн тав тухтай нөхцөлийг бүрэн хангасан, авто терминалын үйлчилгээг нэвтрүүлнэ.
78. Ачаа тээвэр, түгээлтийн шөнийн үйлчилгээнд шинэлэг менежмент нэвтрүүлнэ.
79. “Дугуйн зам” хөтөлбөрийг үргэлжлүүлж, стандартын дагуу тохижилт, гэрэлтүүлэг бүхий дугуйн замын шинэ сүлжээ байгуулж, дугуйн зогсоолын дэд бүтцийг өргөжүүлнэ.


#### Утаагүй хот

#### ШИЙДЭЛ 1. Гэр хорооллын халаалтын олон төрөлт шийдэл.

80. Сайжруулсан түлш үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, түлш нөөцлөх, түгээх, борлуулах цэгүүдийг өргөтгөн, иргэдэд хүртээмжтэй сүлжээг бүрдүүлнэ.
81. Агаарын чанарын бүсэд байгаа айл өрх, ААН, байгууллагуудын сайжруулсан түлшний нийлүүлэлтийг бүрэн хангах нөхцлийг бүрдүүлнэ.
82. Төвлөрсөн дулаанд холбогдох боломжгүй гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж байгууллагыг хийн хангамжид холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
83. Төвийн гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж байгууллагыг төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
84. Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлнэ.
85. Цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхийг төвийн шугамд холбож, гэр хорооллын айл өрхийн шөнийн цахилгаан эрчим хүчийг хөнгөлөх ажлыг чанаржуулна.
86. Цахилгаан эрчим хүчний хөнгөлөлтийн тарифанд гэр хороололд байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг ээлж дараалалтайгаар хамруулна.

#### ШИЙДЭЛ 2. Тээврийн хэрэгсэлтэй үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулна.

87. Тээврийн хэрэгсэлд тавих хяналт үзлэгийг чанаржуулж, нийтийн тээврийн дизель автобус, ачааны автомашинд тортог шүүгч суурилуулна.
88. Автобензин, дизелийн түлшний стандарт, чанарын хяналтыг сайжруулна.



89. Агаар, орчны чанарын хяналт шинжилгээний тасралтгүй ажиллагааг хангаж, хүний нөөцийг чадавхжуулна.

## **Орлогод нийцсэн орон сууцтай Улаанбаатар**

**ШИЙДЭЛ 1. Гэр хорооллын айл өрхийн орон сууц, ахуйн нөхцөлийг сайжруулна.**

90. Өмчилсөн газартаа цэвэр бохироо шийдсэн, тохилог орон сууц барих айл өрхүүдийг дэмжиж, "Ногоон хувийн орон сууц" загвар төсөлд хамруулна.
91. "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төслийн хүрээнд Баянхошуу, Сэлбэ, Шар хад, Толгойт, Дэнжийн 1000 дэд төвийн бүтээн байгуулалт, орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
92. Гэр хороололд инженерийн дэд бүтэц бүхий "сервис центр"-ийг нэмэгдүүлнэ.
93. "Хотын төвийн гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх" хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлнэ.
94. Гэр хороолол, зуслангийн шороон замуудыг хатуу хучилттай болгож, тоосжилтыг 50 хувиар бууруулна.
95. Гэр хорооллын айл өрхийг үнс түр хадгалах зориулалтын савтай болгох үйл ажиллагааг авч хэрэгжүүлж, үнсийг дахин боловсруулах үйлдвэр байгуулна.


**ШИЙДЭЛ 2. Оршин суугчдын эрэлтэд нийцсэн, орон сууцны шинэ хорооллуудын бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ.**

96. Хотын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан, шинэ суурьшлын бүсүүдийг үе шаттай хөгжүүлнэ.
97. Орлогод нийцсэн болон түрээслэн өмчлөх орон сууцны хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.
98. Газрыг орон сууцаар солих үйл ажиллагааг эрчимжүүлж, "нэг яндан - нэг орон сууц" зорилт хэрэгжүүлнэ.
99. Нийслэл үнэт цаас гаргаж зах зээлд бэлэн байгаа орон сууцыг худалдан авч, түрээслээд өмчлөх хэлбэрээр иргэдийг орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
100. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийгдсэн байршилд нийтийн болон хувийн орон сууцны хороолол байгуулна.
101. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих төслийг эрчимжүүлнэ.
102. Орон сууцны цахилгаан шатыг шинэчлэл, засварлаж өргөтгөнө.
103. Угсармал орон сууцны шинэчлэлийн ажлыг үргэлжлүүлнэ.

## **Шинэ хот - Хөгжлийн алтан тойрог**

**Шийдэл 1. Шинэ хотуудыг хөгжүүлж, нэг төвт бөөгнөрлөөс олон төвт тогтвортой хөгжил бүхий нутагшил суурьшлын өнөөчтэй тогтолцоог бүрдүүлнэ.**

104. Улаанбаатар хотын тойрог замуудыг байгуулж, шинэ хотуудыг холбон хөгжүүлэх замаар төвлөлийг сааруулна.
105. Их тойруу, Сэлбийн хурдны болон захын дэд төвүүдийг холбосон тойрог замууд барина.
106. Хөшигтийн хөндий дэх нисэх онгоцны шинэ буудлыг ашиглалтад оруулж, "Шинэ Зуунмод хот" (аеро сити) шинэ хотын бүтээн байгуулалтыг үе шаттай хэрэгжүүлнэ.
107. "Их Майдар" хөшөөт цогцолбор, үйлдвэрлэл, аялал жуулчлалын томоохон байгууламж, их дээд сургууль төвлөрсөн, Майдар эко шинэ хотын бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.



108. Био-Сонгино, Туул-Шувуу, Партизан-Жаргалант Гацуурт зэрэг тосгон суурингуудыг нано-биотехнологи, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр хөгжүүлнэ.
109. Богдхан уулын дархан цаазат газар, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар, Туул голын ай савыг түшиглэн гадаад, дотоодын жуулчид, хотын иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх таатай орчныг хөгжүүлнэ.
110. Ноос ноолуур, арьс ширний анхан шатны боловсруулалт, тээвэр логистик, бөөний худалдаа, хүнсний жижиг дунд үйлдвэрлэл төвлөрсөн Эмээлт-Аргалант шинэ хотын бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.

## **Хүртээмжтэй, чанартай боловсрол**

**ШИЙДЭЛ 1.** Сургууль, цэцэрлэгийн барилга, байгууламжийг үе шаттай нэмэгдүүлнэ.

111. Цэцэрлэгийн барилга, байгууламжийг шинээр барьж байгуулах, өргөтгөл хийх замаар сургуулийн өмнөх боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
112. Байгууллагын дэргэдэх цэцэрлэг байгуулах үйл ажиллагааг бүхий л талаар дэмжиж, мэргэжлийн байгууллагуудын хамтарсан зөвлөн туслах баг ажиллуулна.
113. Сургуулийн барилга, байгууламжийг шинээр барих, өргөтгөх замаар нэг багшид ногдох хүүхдийн тоог бууруулснаар сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг сайжруулна.
114. Нийслэл, дүүргийн хэмжээнд экологийн боловсролыг дэмжин, дүүрэг бүрд нэг сургууль, нэг цэцэрлэгийг түшиглүүлэн экологийн боловсролын төв, байгалийн түшиц лаборатори байгуулна.
115. Дүүрэг бүрд энгийн виртуал орчинтой сургууль, цэцэрлэг байгуулах замаар технологийн дэвшил ашиглан хүүхэд Монгол ахуйтай танилцах боломжийг өргөжүүлнэ.

**ШИЙДЭЛ 2.** Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан, бүтээлч, чадварлаг багш, хүний нөөцөөр хангана.

116. Нийслэлийн хэмжээнд дутагдалтай байгаа багшийн нөөцийг бэлтгэх асуудлыг БСШУСЯ, БМДИ-тэй хамтран шийдвэрлэнэ. Хөрвөх сургалтын бодлогыг дэмжинэ.
117. Багш нарыг гадаад, дотоодод сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлнэ.
118. Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг сайжруулж, индексийн урамшууллыг нэмэгдүүлж, олгох журмыг үргэлжлүүлнэ.

**ШИЙДЭЛ 3.** Онлайн, зайн сургалтыг хөгжүүлнэ.

119. Онлайн, зайн сургалтын нэгдсэн платформыг нэвтрүүлнэ.
120. Насан туршийн боловсролын онлайн болон явуулын сургалтын үйлчилгээг өргөжүүлж, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлнэ.
121. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний хуулийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах хүний нөөц, орчин, техник тоног төхөөрөмж, хүнсний хангамжийн эрэлт хэрэгцээ, нийлүүлэлтийн бэлтгэл ажлыг тодорхой үе шаттай хэрэгжүүлж, сургуулийг эрүүл аюулгүй хүнсээр хангана.

## **Хүн төвтэй эрүүл мэндийн үйлчилгээ**

**ШИЙДЭЛ 1.** Хотын хүн амыг орчин үеийн оношилгоо, эмчилгээгээр үйлчлүүлэх нөхцөлийг сайжруулна.



122. Нийслэлийн эмнэлгийн тусламж үйлчилгээний нэгдсэн зохицуулалттай бүсчилсэн сүлжээг байгуулна.
123. Нийслэлийн Түргэн тусламжийн төвийн барилгыг барьж, ашиглалтад оруулна.
124. Нийслэлийн эх хүүхдийн нэгдсэн эмнэлгийг бүрэн ашиглалтад оруулж, үйл ажиллагааг жигдрүүлнэ.
125. Өрхийн эмнэлгийн статусыг тодорхой болгож, санхүүжилтийг оновчтой хэлбэрээр шийдвэрлэнэ.
126. Стандартын шаардлага хангасан байртай өрхийн эрүүл мэндийн төвийн тоог нэмэгдүүлж, хүчин чадал, хүртээмжийг сайжруулна.
127. Нийслэлийн Наркологийн эмнэлгийн барилгыг барьж, ашиглалтад оруулна.
128. Эмчилгээ, оношилгоо, сургалтад алсын зайн анагаах ухааныг /теле медицин/ өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх түвшинд ашиглаж хэвшинэ.

**ШИЙДЭЛ 2.** Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдүүлнэ.

129. Дүүргийн нэгдсэн эмнэлэг, амаржих газар, төрөлжсөн эмнэлгүүдэд цахим програмыг үе шаттайгаар нэвтрүүлнэ.
130. Цахим эрүүл мэнд хөтөлбөрийн хүрээнд өрх, дүүргийн Эрүүл мэндийн төвийн “E-Health” програм хангамжийг төрийн мэдээллийн “ХУР” системтэй холбоно.


**ШИЙДЭЛ 3.** Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бүрдүүлнэ.

131. Дүүрэг бүрд Нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулна.
132. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.
133. Нийслэлийн хүн амын халдварт бус өвчлөлийг бууруулах “Эрүүл гэр бүл” төсөл хэрэгжүүлнэ.
134. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эмчлэн эрүүлжүүлэх аян өрнүүлнэ.
135. Нийслэлийн 9 дүүргийн эмнэлгүүдэд эрэгтэйчүүдийн кабинет байгуулна.
136. Эрүүл зохистой хооллолтыг дэмжих хөдөлгөөн өрнүүлнэ.
137. Хүүхдийг осол гэмтлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх “Эрсдэлгүй ирээдүйн төлөө хамтдаа” хөдөлгөөн, аяныг үе шаттай зохион байгуулна.

## Хүнд ээлтэй хот

**ШИЙДЭЛ 1.** Хүүхэд, залуучууд, тусгай хэрэгцээт иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, хөгжих боломжийг хангасан хүндээ ээлтэй хот болно.

138. Хотын гудамж талбай орон сууц, гэр хорооллын дундах хүүхдийн тоглоомын талбайг олон улсын стандартад бүрэн нийцүүлж, шаардлагатай газруудад шинээр байгуулна.
139. Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, хүүхэд олноор зорчих хэсгийг гарц, гэрлэн дохио, хурд сааруулагч, камертай болгоно.
140. Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх төвийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.
141. Хүүхэд, оюутан, залуучууд, өсвөр үеийнхнийг гаднын сөрөг нөлөө, бусдын дарамт, гэмт хэрэгт өртөх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхээс сэргийлэх, цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
142. Дүүрэг бүрд тусгай хэрэгцээт хүүхдийн төвийг байгуулна.



143. Стандартад нийцсэн явган замыг шинээр болон шинэчилж сайжруулах ажлыг үргэлжлүүлнэ.
144. Залуус, оюутны жишиг төвийг хотын захиргааны шинэ байрыг түшиглэн байгуулна.
145. Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэдийн эрх, оролцоог хангаж, нөхөн сэргээх эмчилгээ, сувилгаа болон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
146. Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэд хэрэгцээт үйлчилгээгээ авах нөхцөлийг төрийн болон бусад бүх байгууллагад бүрдүүлнэ.
147. Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид санхүүгийн урамшуулал олгож, тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд төлөх төлбөрийн хэмжээ, төрийн байгууллагын удирдах ажилтны хариуцлагыг нэмэгдүүлнэ.
148. Байнгын асаргаа шаардлагатай тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэд, ахмадуудад зориулсан төрөлжсөн асрамж, сувиллын үйлчилгээний тогтолцоог сайжруулна.


## Амьдралын таатай орчин бүхий эрүүл, цэвэр хот

### ШИЙДЭЛ 1. Хотын иргэдийн эрүүл, цэвэр, амьдралын таатай орчинг бий болгоно.

149. Улаанбаатар хотын хог хаягдлыг ангилан ялгаж, цуглуулж тээвэрлэх дэвшилтэт цогц арга, технологийг нэвтрүүлж, хог шатааж эрчим хүч гаргах, дахин боловсруулах үйлдвэрүүдийг дэмжих замаар төвлөрсөн цэгт дарж булагдах хог хаягдлын хэмжээг бууруулна.
150. Хог хаягдлын төвлөрсөн цэгүүдийн нөхцөлийг сайжруулж, олон жил хог дарж булсан ландфилын талбайг үе шаттайгаар хэсэгчлэн нөхөн сэргээлт хийнэ.
151. Хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамж төлөх нээлттэй ил тод хялбаршуулсан цахим системийг нэвтрүүлнэ.
152. Аюултай хог хаягдлыг бүртгэлжүүлж, ангилан ялгаж, тээвэрлэх, түр хадгалах, саармагжуулан устгах тогтолцоог бий болгоно.
153. Гэр хорооллын нүхэн жорлонг шинэчлэхэд дэмжлэг үзүүлж, бохир цуглуулж, тээвэрлэх, байгальд ээлтэй аргаар устгах арга технологийг нэвтрүүлэн хөрсний бохирдлыг багасгана.
154. Нийтийн эзэмшлийн зам талбай, нийтийн тээврийн автобус, автобусны буудал, зогсоол, тохижилтын элементүүдэд угаалга, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийдэг болно.

### ШИЙДЭЛ 2. Улаанбаатар хотыг усны нөөцийн хомсдолоос сэргийлж, усны ухамсартай хэрэглээг төлөвшүүлж, хуримтлал, хангамжыг сайжруулна.

155. Улаанбаатар хотын ус хангамжийн Баруун шинэ эх үүсвэрийг Сонгинохайрхан уулын бэлд шинээр барьж, ашиглалтад оруулна.
156. “Улаанбаатар хотын ус хангамжийн шугам хоолойг газар ухалгүйгээр шуудуугүй технологиор доторлох төслийг хэрэгжүүлнэ.
157. Гадаргуугийн усыг унд-ахуйн зориулалтаар ашиглахыг дэмжиж, “Туул усан цогцолбор” төслийг эрчимжүүлнэ.
158. Цэвэрлэх байгууламжаас байгальд хаягдах усыг дахин боловсруулж, дулааны станцын технологийн хэрэгцээнд ашиглах замаар ундны цэвэр усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах явдлыг хязгаарлах үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлнэ.
159. Улаанбаатар хотод 250,0 мянган метр куб бохир ус цэвэршүүлэх цэвэрлэх байгууламж шинээр барих ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна.



160. Төв цэвэрлэх байгууламжаас гарах лагийг дахин боловсруулах, хатаах байгууламж барина.
161. Эмээлт аж үйлдвэрийн паркийн бүтээн байгуулалтын үргэлжлүүлж, арьс шир, өлөн, ноос ноолуурын бохир усыг цэвэрлэх Урьдчилан цэвэрлэх байгууламж /Харгиа/-ийг Улаанбаатар хотоос үе шаттай гаргана
162. Орон нутгийн өмчит цэвэрлэх байгууламжийн эрүүл ахуйн болон энгийн хамгаалалтын бүсийг баталгаажуулж, дэглэмийг мөрдүүлнэ.
163. Улаанбаатар хот, түүний ойр орчмын голын эх, ус намаг бүхий газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтад авч, барилгажихаас сэргийлнэ.
164. Туул, Дунд голын дагуух барилга, байгууламжийн зоорийн давхрыг газар доорх усны түвшин дээшлэлт болон үерийн усанд автах болзошгүй эрсдэлээс сэргийлж, хөрсний усыг зайлуулах барилга байгууламжийг барина.
165. Өвлийн улиралд халиа дошин үүсдэг, газрын доорх усны түвшин дээшилж буй байршлуудад хөрсний усыг зайлуулах инженерийн шугам сүлжээг үе шаттай байгуулна.
166. Усыг үр ашиггүй зарцуулж буй байдлыг багасгаж, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа усны үнийг нэмэгдүүлж, үнийг бодит түвшинд барьж ажиллана.

### Ногоон байгууламж бүхий эко хот


**ШИЙДЭЛ 1.** Хотын экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, амьдралын таатай орчинг бүрдүүлсэн ногоон хот болно.

167. Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн болон хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлнэ.
168. Дүүрэг бүрд цэцэрлэгт хүрээлэн байгуулна.
169. Туул, Сэлбэ, Улиастай голуудын эрэг дагуу амралт зугаалгын цогцолбор байгуулна.
170. Гэр хорооллын айл өрх хашаандаа ногоон байгууламж бүхий бичил цэцэрлэг байгуулах санаачилгыг бүх талаар дэмжинэ.
171. Улаанбаатар хотын уур амьсгал, орчны нөхцөлд тэсвэртэй ойн экосистемийг бий болгох замаар хотын ой /ногоон бүс, ногоон байгууламж/ арчилгаа хамгааллын тогтвортой менежментийг хэрэгжүүлнэ.
172. Самбаллхүндэвийн оршуулгын газарт дурсгалын цэцэрлэгт хүрээлэн бүхий тохижилттой оршуулгын үйлчилгээний мэдээллийн нэгдсэн төвийг бий болгоно.
173. Нийслэлийн нутаг дэвсгэр дэх оршуулгын үйлчилгээний зохистой менежментийг бий болгож, оршуулгын газруудыг ойжуулна.
174. Улаанбаатар хотын ойн түймрээс хамгаалах шороон зурвасуудыг шинээр болон шинэчлэн байгуулах замаар түймрийн эрсдэлийг бууруулна.
175. “Шарилжгүй Улаанбаатар” аяныг үргэлжлүүлнэ.

### Аюулгүй хот

**ШИЙДЭЛ 1.** Нийслэл хотод үйлдэгдэж буй гэмт хэргийн тоог бууруулж иргэдийн амар тайван, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

176. Нийслэл хотын иргэдийн амьдрах, ая тухтай орчныг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний зохион байгуулалтыг сайжруулах “Аюулгүй хот” төслийг үргэлжлүүлнэ.





### **Сүхбаатар дүүрэг**

197. Дүүргийн нийтийн номын сан барьж, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн дуусаагүй барилгуудыг ашиглалтад оруулж, шаардлагатай хороодод шинээр байгуулна.
198. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, чийрэгжүүлэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.
199. Иргэд оршин суугаа байр, хотхон, гудамжиндаа тохижилт хийх санаачилгыг дэмжиж, агаар, хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор мод, бут, сөөг тариалах ажлыг санаачлан хийх нөхөрлөлийн хэлбэрийг дэмжиж, ургуулсан тоогоор урамшуулал олгох систем бий болгоно.
200. 1970-аад оноос өмнө баригдсан угсармал орон сууцны дулаан, эрчим хүчний алдагдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авч, нийтийн эзэмшлийн зам талбайн ус зайлуулах шугам хоолойн ашиглалтыг сайжруулна.
201. Хог хаягдлыг ангилан ялгаж хэвшүүлэх, хаягдал түүхий эдийн шил, төмөр гэх мэт биет сав баглаа боодлыг худалдааны цэгүүдэд хүлээн авч үйлчилдэг олон улсын туршлагыг хэрэгжүүлнэ.

### **Чингэлтэй дүүрэг**


202. Төрөх эмнэлэг болон тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэдийн төрөлжсөн эмнэлэг барина.
203. Ажил олгогчдыг шинэ ажлын байраа нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, залуучуудаа дадлагажуулан бэлтгэж, ажлын байраар хангахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
204. Гэр хороололд инженерийн дэд бүтэц бүхий сервис центр байгуулах ажлыг эрчимжүүлэн, иргэд амины орон сууц барихад дэмжлэг үзүүлж, модон жорлонг био жорлонгоор шинэчлэх ажлыг эрчимжүүлнэ.
205. Гэр хорооллыг орон сууцжуулах, газар чөлөөлөх асуудлыг шийдвэрлэнэ.
206. Дүүргийн ногоон байгууламжийг нэмэгдүүлж, хашаандаа мод тарьсан айлыг урамшуулдаг тогтолцоог бий болгоно.

### **Хан-Уул дүүрэг**

207. Гурав дахь шатны эмнэлгийн үйлчилгээг дүүрэгтээ авах боломж бүрдүүлж, жишиг эмнэлэг байгуулна.
208. Богд уулын ойн санг нэмэгдүүлж, Туул голын урсцыг сайжруулах, сав газрыг хамгаалж, эрэг дагуу амралт зугаалгын цогцолбор барина.
209. Арьс ширний үйлдвэрүүдийг суурьшлын бүсээс гаргана.
210. Алслагдсан гэр хорооллыг цахилгаанд бүрэн холбож, гудамж талбайг иж бүрэн гэрэлтүүлэгтэй болгож, 4, 5 дугаар хорооны хилийн заагаас Туул голын дээгүүр гарах авто зам бүхий гүүрэн байгууламж барина.
211. Залуу гэр бүлд зориулсан эко зуслангийн байр хөтөлбөр хэрэгжүүлнэ.

### **Сонгинохайрхан дүүрэг**

212. Дүүргийн хэмжээнд сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, шаардлагатай хороодод шинээр барьж, олон улсын хөтөлбөртэй, чанарын шаардлага хангасан хоёроос доошгүй сургууль байгуулна.
213. Иргэдэд төрийн анхан шатны үйлчилгээг нэг цэгээс тав тухтай хүргэх орчин нөхцөлийг сайжруулна.
214. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд эмнэлэг, сургууль, цэцэрлэг, бизнес инкубатор төв бүхий “Толгойт дэд төв”-ийг ашиглалтад оруулж, шаардлагатай байршлуудад бичил дэд төвүүд байгуулна.
215. Орон сууцжуулах хөтөлбөрийг шинэ зохион байгуулалтаар өргөжүүлж, иргэдийг орон сууцаар хангах нөхцлийг бүрдүүлнэ.



216. Халаалтын зуухнуудыг үе шаттайгаар буулгаж, хэрэглэгчдийг төвлөрсөн болон хэсэгчилсэн эх үүсвэрт холбоно.

#### **Багануур дүүрэг**

217. Багануур дүүргийг орон нутгийн зэрэглэлтэй хот болгоно.

218. Дэд бүтэц, аж үйлдвэрлэлийн нөөцөд тулгуурлан мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв байгуулна.

219. Нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа зарим хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг Багануур дүүрэгт шилжүүлэх зорилгоор ус сувагжуулалт, эрчим хүчний шугам сүлжээ, инженерийн дэд бүтцийг нэмэгдүүлнэ.

220. Багануурын уурхайн хүрэн нүүрсийг ашиглан жилд 30 мянган тонноос багагүй утаагүй түлшний үйлдвэр байгуулна.

221. Гэр хорооллуудад цэвэр, бохир ус, халаалтын хэсэгчилсэн инженерийн байгууламж барьж, цахилгаанд үе шаттай холбож, гудамж талбайг иж бүрэн гэрэлтүүлэгтэй болгож, хуучны орон сууцны дулаан алдагдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авч, өнгө үзэмжийг нь сайжруулна.

#### **Налайх дүүрэг**

222. Налайх дүүргийг орон нутгийн зэрэглэлтэй хот болгоно.

223. Барилгын материалын үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагааг эрчимжүүлж, олон улсын ачаа тээвэр, логистик, бөөний худалдааны төвийг байгуулж, дулааны станцын өргөтгөл шинэчлэлтийг хийж, эрчим хүчний нэмэлт шинэ дэд станц, Таван толгойн сайжруулсан түлшний үйлдвэр-II барьж, ажлын байр шинээр бий болгоно.

224. 300 ортой эрүүл мэндийн шинэ эмнэлэг, Голомт цогцолбор сургууль, 103 дугаар сургуулийн шинэ байр, шаардлагатай хороонд шинээр цэцэрлэг барьж, олон нийтийн болон ахмадын чөлөөт цагийн төвтэй болно.

225. Дүүргийн төв, орон сууцны болон гэр хорооллуудад авто зам, явган хүний зам барьж, айл өрхийг эрчим хүч, дулааны эх үүсвэрт холбоно.

226. Аялал жуулчлал, бизнес, соёлын харилцааг хөгжүүлж, “Залуус хөгжлийн цогцолбор” байгуулна.

#### **Багахангай дүүрэг**

227. Шинээр дулааны станц барьж, гэр хорооллыг дулаан, цэвэр, бохир усны инженерийн байгууламжид холбоно.

228. Соёлын ордон, сурагчийн дотуур байр шинээр барина.

229. “Багахангай үйлдвэр технологийн парк”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлж, шил, шилэн бүтээгдэхүүн, барилгын шилэн хийцийн үйлдвэрийг барьж байгуулах, санал санаачилгыг дэмжиж, мах боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг сэргээнэ.

230. Улаанбаатар төмөр замын ачиж буулгах терминалыг байгуулна.

231. Монголын уламжлалт морин уралдааныг орчин үеийн стандарт шаардлагад нийцүүлэх, морин тойруулга, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх төвтэй болно.





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.07.09 № 1240  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН  
ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Багахангай дүүргийн Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Багахангай дүүргийн Монгол Ардын намын хорооны Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн


иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Багахангай дүүргийн Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /...<sup>9</sup>хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Багахангай дүүргийн сонгуулийн хороонд

Хавсралт: <sup>9</sup>... хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР



## ЭРХЭМ СОНГОГЧ ТАНАА:

Өнөөгийн Багахангайчууд бидэнд дүүргийн өсөлт, хөгжлийг түүчээлэн үргэлжлүүлэх хүндтэй бөгөөд хариуцлагатай үүрэг ногдож байна.

Дүүргийн Монгол Ардын Намын хороо дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцохдоо хүнээ дээдлэх үзэлд суурилсан.

“Бид зүтгэнэ - Хамтдаа хөгжинэ” мөрийн хөтөлбөртөө ирээдүйг бүтээх бодлого, хүсэл эрмэлзлээ тусган сонгогч түмэн олон Та бүхэндээ толилуулж байна.

Монгол Ардын Намаас нэр дэвшигчдэд итгэл хүлээлгэж, өөрсдийнхөө төлөө, төрөлх дүүргээ талын хот болгон хөгжүүлэхийн төлөө хамтдаа хүчээ нэгтгэн зүтгэе.

Багахангай дүүргийн Монгол Ардын намаас Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлыг сонгох 2020 оны ээлжит сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрийн алсын харааг:

1. Мэдлэг боловсролтой, чадварлаг, эрүүл иргэн
2. Нэг өрх- Нэг ажлын байр
3. Хүн амын өсөлт- Эдийн засгийн хөгжил
4. Бизнесийн таатай орчин бүрдсэн үйлдвэржсэн бүс
5. Амар тайван, аз жаргалтай, эко дүүрэг болно гэж тодорхойлж байна.

## НЭГ: НИЙГМИЙН ХӨГЖИЛ

### **Зорилт 1. Мэдлэг, боловсролтой, хариуцлагатай иргэн**

Хүүхэд, залуучууд, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**


1. Дүүрэгт 500 хүний суудалтай Соёлын ордны барилгыг барьж ашиглалтад оруулан, соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, орон нутгийг судлах танхимын үзмэрийг баяжуулна.

2. 2 дугаар хороонд спорт цогцолборын барилга барих ажлыг эхлүүлнэ.

3. Хүүхэддэйн театр, хүүхдийн номын сан, хүүхдэд зориулсан бүтээл зэрэг соёлын өвийг түгээн дэлгэрүүлж, хүүхэд хөгжлийн төвд шаардлагатай сургалт, танин мэдэхүйн дэмжлэгийг үзүүлнэ.

4. Багахангай дүүрэгт Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв болон Хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарын сургуулиудын дадлага сургуулилтын төвтэй болох асуудлыг үе шаттайгаар шийдвэрлүүлнэ.

5. Нийслэлийн төвийн дүүргүүдэд үйл ажиллагаа явуулж буй цэргийн анги, төрийн зарим байгууллагыг дүүрэгт шилжүүлэх боломжийг судалж, шийдвэрлүүлэн ажиллана.



6. Ээлжийн ажилтай иргэд, алслагдсан өртөө зөрлөг, малчин өрхийн хүүхдүүдийг ая тухтай сурч боловсроход дэмжлэг үзүүлэн хүүхэд харах үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

7. Алслагдсан өртөө зөрлөг, малчдын хүүхдийн сурч боловсрох орчныг сайжруулах зорилгоор 100 хүүхдийн ортой сургуулийн дотуур байр барих ажлыг эхлүүлнэ.

8. Сургалтын амжилт, чанарыг дээшлүүлэх, улс, нийслэлийн олимпиад, уралдаан тэмцээнд оролцуулах, сурагчдын авьяас чадварыг нээн хөгжүүлэх сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагааг бүх талаар дэмжиж, дүүргийн өсвөрийн шигшээ багуудыг бий болгоно.

9. Сурагчдад сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх сэтгэл зүйчийг ажиллуулна.

10. СӨБ-ын байгууллагуудыг шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүнээр ханган 44, 207 дугаар цэцэрлэгийн гадна тохижилтыг хүүхдэд ээлтэй, эко орчин болгоно.

11. Гэрлэх ёслолын ордонтой хамтран залуу гэр бүл болон алт, мөнгөн гэр бүлийн тангараг өргөх ёслолын ажиллагааг дүүрэгтээ үргэлжлүүлэн зохион байгуулна.

12. Иргэдийн нийтийн соёлыг дээшлүүлж идэвхтэй хөдөлгөөн хийх, уулын болон явган аялал, дугуйн спорт зэрэг нийтийн биеийн тамирын төрлүүдийг дэмжиж, хамрах хүрээг өргөжүүлнэ.

13. Дүүрэгт иргэд, олон нийтэд зориулсан усан бассейн бүхий боулингийн төв байгуулах ажлыг эхлүүлнэ.

14. Соёлын биет болон биет бус өвийг хамгаалан, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулна.

15. Мэргэжлийн холбоодтой хамтран дүүрэгт улс, бүсийн чанартай тэмцээн уралдаан зохион байгуулж дүүргийн иргэдийн ур чадвар, нийтийн биеийн тамираар хичээллэх нөхцөл боломжийг нэмэгдүүлнэ.

16. Тусгай хэрэгцээт /хөгжлийн бэрхшээл/-тэй хүүхдийг үе тэнгийнхэнтэйгээ хамт суралцах нийгэм сэтгэлзүй, сургалт, дэд бүтцийн таатай орчныг бүрдүүлнэ.

17. Хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудалд онцгойлон анхаарч, мэргэжлээ сонгох зөвлөх үйлчилгээг нэвтрүүлнэ.

18. Хүүхдийг амьдрах ухаан, бие даах чадвар, харилцааны зөв дадал хэвшилд төлөвшүүлэх "Оюунлаг Багахангайчууд" хөтөлбөр хэрэгжүүлнэ.

19. Залуучуудын сурч боловсрох, хөдөлмөрлөх таатай орчныг бүрдүүлж, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлнэ.

20. Хүүхэд, залуучуудад үндэсний өв уламжлал, эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх, хотын соёлд суралцуулах, гэр бүлийн боловсрол олгож, чөлөөт цагийн орчин нөхцөлийг сайжруулах санал санаачилгыг дэмжиж хамтран ажиллана.

21. Залуучууд, залуу гэр бүлийг "Орлогод нийцсэн-Орон сууц" хөтөлбөрт хамруулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.

22. Насан туршийн боловсролын төвийг бие даасан байдлаар байгуулж иргэд, хүүхэд, залуучуудад насан туршийн боловсрол олгох цогц арга хэмжээ зохион байгуулах

## **Зорилт 2. Эрүүл иргэнтэй дүүрэг**

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй хүргэн, эрүүл мэндийн боловсрол олгож, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрүүл иргэнтэй дүүрэг болно.

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

1. Дүүргийн Эрүүл мэндийн төвийн бүтэц, орон тоог нэмэгдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.

2. Эмнэлгийн эмч, ажилчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, мэргэшсэн боловсон хүчнээр хангана.

3. Орон нутагтаа жил бүр нарийн мэргэжлийн эмч нартай /зүрх судас, мэдрэл, эмэгтэйчүүд, дотор, нүд, чих хамар хоолой гэх мэт/ хамтарч үзлэг оношилгоо хийлгэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

4. “Эрүүл орчин- Иргэдийн сайн сайхан” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

5. Иргэдийн нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх зөв дадал хэвшилд сургах, эрүүл зохистой хооллолтыг дэмжих хөдөлгөөн өрнүүлнэ.

6. Эрүүл шүд - Эрүүл хүүхэд хөтөлбөрийг үргэлжлүүлж ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлэх “Эрүүл ирээдүй хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.

7. Иргэдэд эрүүл мэндийн бүх талын боловсролыг ЕБС-д суралцаж байх үеэс олгож, эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх чадавхыг эзэмшүүлнэ.

8. Хуучин 10 ортой эмнэлгийн барилгыг засварлаж улирлын чанартай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийн сувилал болгох ажлыг эхлүүлнэ.


## **Зорилт 3. Иргэдэд хүртээмжтэй нийгмийн хамгаалал**

Дүүргийн хүүхэд, ахмад настан, тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй болон амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд чиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, нийгмийн хамгааллын хосолмол бүтцийг бий болгоно.

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

1. Хүүхэд, ахмад настан, тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдэд чиглэсэн эрүүлжүүлэх, чийрэгжүүлэн эмчлэх, сэргээн засах үйлчилгээ үзүүлдэг холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

2. Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийн эрх, оролцоог хангаж, нөхөн сэргээх эмчилгээ сувилгаа болон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.



3. Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлж “Эрсдэлгүй ирээдүйн төлөө хамтдаа” аяныг үе шаттай зохион байгуулна.

4. Ахмадын өргөөний хашааг барьж, гадна тохижилтыг хийж гүйцэтгэнэ.

## **ХОЁР: САНХҮҮ, БИЗНЕСИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ**

### **Зорилт 1. Бизнесийн салбарын хөгжил**

Шинээр бизнес эхлэх эхний үе шатны хүндрэлийг даван туулах, цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулах, зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулахын тулд Жижиг дунд үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг борлуулах сүлжээ бий болгоно.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

1. Багахангай дүүрэгт малын гаралтай түүхий эд, арьс шир, сүү, сүүн бүтээгдэхүүн худалдан авах, боловсруулах үйлдвэрлэл үйлчилгээг төвлөрүүлэх, малын тэжээлийн усалгаатай газар тариалан хөгжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.

2. Хороодын бичил бизнесийг дэмжих “Хадгаламж зээлийн хоршоо”-ны үйл ажиллагааг тогтмолжуулан жижиг дунд үйлдвэрлэл, бичил бизнес эрхлэгчдийг дэмжинэ.

3. Дүүрэгт Эдийн засгийн үр ашигтай гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж хамтран ажиллана.

4. Багахангай дүүргийн Мах боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг сэргээнэ

5. Малыг эрүүлжүүлэх, чанар, үүлдрийг сайжруулах ажлыг эрчимжүүлэн малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулна.

6. Мал амьтныг халдварт болон паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх, вакцинжуулах, эмчлэх ажлыг зохион байгуулна.


7. “Багахангайн үйлдвэрлэл технологийн парк”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлж, шил, шилэн бүтээгдэхүүн, барилгын шилэн хийцийн үйлдвэрийг барьж байгуулах, санал санаачилгыг дэмжиж ажиллана.

8. Дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвөөр дамжуулан жижиг, дунд, бичил бизнес эрхлэгчдийн санхүүгийн асуудал буюу зээл тусламжид хамрагдах нөхцөлийг бүрдүүлнэ.

### **Зорилт 2. “Нэг өрх - Нэг ажлын байр”**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

1. Ажлын байр бий болгоход хувийн хэвшилтэй нягт хамтран ажиллана.



2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн ажил мэргэжилгүй иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгох жижиг зээл, төсөл хөтөлбөрт хамрагдах сургалт зохион байгуулж, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.

3. Улс, нийслэл, орон нутгийн хөрөнгө оруулалтаар дүүрэгт хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэгч байгууллагад орон нутгийн иргэдээс тодорхой тооны иргэдийг ажлын байраар хангах асуудлыг гэрээнд тусгуулж шийдвэрлэн ажиллана.

4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажилд иргэдийн бүлгийн оролцоог нэмэгдүүлнэ.

5. Зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг нэмэгдүүлнэ.

6. Зорилтот бүлгийн иргэдийн санал санаачилгыг дэмжин төсөл хөтөлбөрт хамруулан өрхийн орлогыг нь нэмэгдүүлнэ.

7. Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн гишүүдийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

8. Иргэдийн туршлага, ур чадварт түшиглэн хувиараа хөдөлмөр эрхлэх боломжийг дэмжинэ.

9. Ахмад настны орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх ажил эрхлэлт, зөвлөх үйлчилгээг үр дүнтэй хэлбэрээр үргэлжлүүлнэ.

10. Орон сууцуудын зоорины давхрыг ард иргэдэд ашиглуулах нөхцөл бололцоог бүрдүүлнэ.

### ГУРАВ: ЗАСАГЛАЛЫН ХӨГЖИЛ


**Зорилт 1.** Хүн төвтэй, олон нийтийн оролцоотой, иргэдэд хүрсэн төрийн үйлчилгээг хэвшүүлнэ.

#### Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Иргэдийг дүүргийн байгууллага, аж ахуйн нэгжүүдээс шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж, иргэдэд ажлаа тогтмол тайлагнана.

2. Дүүргийн төрийн захиргааны байгууллагуудад ажиллах төрийн албан хаагчдыг шударга, нээлттэй зарчмаар сонгон шалгаруулж төрийн албыг улам чадварлаг болгоно.

3. Төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх, цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, хандлагыг эрс шинэчилнэ.



4. Дүүргийн гадаад харилцааг өргөжүүлэн гадаад улс орон, хотуудтай харилцаа тогтоож, харилцан туршлага солилцоно.
5. Дүүргийн нэг цэгийн үйлчилгээ болон явуулын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
6. Төрийн байгууллагуудын үйлчилгээнд хэрэглэгчийн үнэлгээг тогтмол хийж хэвшинэ.
7. Орон нутгийн төсөв түүний зарцуулалтыг олон нийтэд нээлттэй мэдээлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
8. Төрийн албыг мэргэшсэн, чадварлаг хүний нөөцөөр бүрдүүлж, төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэхэд анхаарна.
9. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт үе шаттайгаар шилжүүлж, хороодоос иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.
10. Багахангай дүүрэгт “Нар харах” үйл ажиллагааг өргөжүүлэн, орон нутгийн брэнд аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгоно.
11. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
12. Цагдаагийн хэлтсийн гадна хашаа, тохижилтын ажлыг хийж дуусгана.
13. Цэргийн штаб, Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын бие бүрэлдэхүүн дадлага хийх, чийрэгжүүлэх спорт сургалтын талбайг бий болгож иж бүрэн тохижуулна.
14. Багахангай дүүргийн ЗДТГ-ын байранд их засвар хийнэ.

## **ДӨРӨВ: ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ**


### **Зорилт 1. Дэд бүтцийг сайжруулах**

Дэд бүтцийг түлхүү хөгжүүлэх, бүтээн байгуулалтад хувийн хэвшлийг оролцуулах, гадаад, дотоодын зээл, тусламжийг татах чиглэл баримтална.

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

1. Богд хаан төмөр замыг Багахангай өртөөнд холбох асуудлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.
2. Багахангай дүүргийн 2 дугаар хорооны хатуу хучилттай авто замыг УБ-Чойр чиглэлтэй холбох 1,3 км авто замын ажлыг гүйцэтгэнэ.
3. Багахангай дүүргийн төмөр замын 508 дугаар километр дэх гармыг хаалттай гармаар тоноглож, зорчигчдын буух, суух тавцанг өргөтгөж засварлана.
4. Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлэн, орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.

5. Дэд бүтцийн байгууллагуудад машин механизм, техник хэрэгслийн парк шинэчлэл хийнэ.
6. 2 дугаар хорооны байрнуудын дулааны алдагдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.
7. Багахангай дүүрэгт 20-25 мвт-ын хүчин чадал бүхий нэгдсэн дулааны станцын зураг төсөв боловсруулах, барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.
8. Гэр хорооллуудад цэвэр, бохир ус, халаалтын хэсэгчилсэн инженерийн байгууламж барих ажлыг эрчимжүүлэх, "Service center" дэд бүтцийн төвийг 2 дугаар хороонд барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.
9. Шинэ суурьшлын бүсүүдийн эрчим хүчний шугам сүлжээг өргөтгөнө.
10. 1 дүгээр хорооны нутагт байгаа нисэх буух зурвас, 2 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх цэргийн ангийн газрыг дүүргийн өмчлөлд шилжүүлэх талаар холбогдох байгууллагуудад уламжилж хууль журмын хүрээнд иргэний зориулалтаар ашиглуулж эхлүүлнэ.
11. Дүүрэгт мах, сүүний хосолмол эрчимжсэн аж ахуй байгуулахад бүх төрлийн дэмжлэг үзүүлнэ.
12. Орон сууцны хороолол доторх болон гудамжны холбоос замуудыг шинэчилж шинээр барих, замын хөдөлгөөний зохион байгуулалтыг сайжруулна.
13. Үерийн далан, суваг шинээр байгуулна.
14. Монголын уламжлалт морин уралдааныг орчин үеийн стандарт шаардлагад нийцүүлэн, дүүрэгт морин тойруулгын төвийг байгуулна.
15. Стандартын дагуу тохижилт гэрэлтүүлэг бүхий дугуйн зам барьж эхлүүлнэ.
16. Дүүргийн 2 дугаар хороонд Улаанбаатар төмөр замын ачиж буулгах терминалыг байгуулна.
17. Нийтийн эзэмшлийн талбайд явган хүний зам шинээр барих ажлыг үргэлжлүүлнэ.
18. 1 дүгээр хороонд байрнуудын орчимд авто машины зогсоол байгуулна.
19. 1 дүгээр хорооны байрнуудын өмнөх авто замын шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ.
20. "Багахангай тохижилт" ОНӨААТҮГ-ын оффисын барилгын зураг төсөв хийлгэнэ.
21. Шинээр суурьшлын бүс байгуулах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж амины орон сууц, хаус хороолол бий болгоно.



22. 2 дугаар хорооны байрнуудын гадна талд авто машины зогсоол байгуулна.

23. Ахуйн болон авто хийн станц, шатахуун түгээх станцыг шинээр барьж ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлнэ.

## **Зорилт 2. Иргэдийн аюулгүй орчныг бүрдүүлэх**

Нийгмийн дэг журмыг сахиулан гэмт хэргийн гаралтыг бууруулж, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

1. Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад галын аюулыг мэдээлэх автомат дохиоллын хэрэгсэл суурилуулах ажлыг зохион байгуулна.

2. Гамшиг осол, галын аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтсүүдийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

3. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авто замын уулзвар, гарцыг өргөтгөх, тэмдэг тэмдэглэгээг сайжруулна.

4. Малын хулгайгаас урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай зохион байгуулж хэргийн мэдээллийг улирал бүр иргэдэд тогтмол, нээлттэй хүргэж ажиллана.

## **ТАВ: БАЙГАЛЬ ОРЧИН, ГЭР ХОРООЛЛЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ**

### **Зорилт 1. Өмчилсөн газар- Тохилог амины орон сууц**

#### **Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

1. Соёлч өрх, орц, байр, гудамж, тэргүүний тохижилттой байгууллага хамт олныг дэмжиж ажиллана.

2. Орон сууц, байр, гудамжуудыг хамарсан “Хөршийн холбоо”, “Иргэдийн бүлэг” зэрэг хамтын амьдралын зөв хэвшлийг бий болгоход хамтарч ажиллана.

3. Дүүргийн орон сууцуудын цахилгаан хангамжийн нөхцөлийг сайжруулах чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4. Дүүргийн 1, 2 дугаар хорооны байр, орц, гэр хорооллуудыг стандартын хаягжилттай болгоно.

5. Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж, хяналтыг сайжруулна.

6. Гэр хорооллын айл өрхийн цэвэр усны хангамжийн стандартыг хангуулахад онцгой анхаарна.

7. 129 айлын орон сууцыг ашиглалтад оруулж, түрээсийн орон сууцны журмаар иргэдийг орон сууцаар хангах бодлого хэрэгжүүлнэ. Мөн дүүрэгт нэн

шаардлагатай байгаа нарийн мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлнэ.

8. Иргэд, аж ахуйн нэгжийн хэрэгцээг бүрэн хангасан сайжруулсан шахмал түлш, хагас коксжсон түлшний хэрэглээг нэмэгдүүлж, байр, сууцны дулаалгыг сайжруулж агаарын бохирдлыг бууруулна.

9. Гэр хорооллын орчин нөхцөлийг сайжруулж био жорлон нэвтрүүлэн, хөрсний бохирдлыг багасгана.

10. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр иргэн, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн санал санаачилгыг дэмжин бичил цэцэрлэгүүдийг нэмэгдүүлж өрх бүр 1 мод аян хэрэгжүүлнэ.

11. Дүүргийн иргэдийн хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах, хүлэмжийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх боломжийг нэмэгдүүлэн, дэмжлэг үзүүлнэ.

12. Малчид, тариаланчдад чиглэсэн техникийн дэвшлийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.

13. Бэлчээрт хөнөөл учруулж буй хортон шавьж, үлийн цагаан оготно, мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэх ажлыг зохион байгуулна.

14. Түгээмэл тархацтай ашигт малтмалыг хуулийн хүрээнд зүй зохистой ашиглах асуудлыг дэмжиж ажиллана.


15. Гар аргаар ашигт малтмал олборлох бичил уурхай эрхлэгчдийг хуулийн хүрээнд дэмжиж байгалийн нөхөн сэргээлт хийх тогтолцоог бүрдүүлж ажиллана

16. Дүүргийн цагдаагийн постны хажууд мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэг бий болгоно.

17. Дүүрэгт тарвага сэлгүүлэн нутагшуулж тал нутгийн эко системийг дэмжинэ.

18. Ундны усны болон мал услах худгийн тоог нэмэгдүүлж өөрөө өөртөө үйлчлэх цахим технологи нэвтрүүлнэ.

19. Дүүргийн хэмжээнд шаардлагатай газруудад нөхөн сэргээлт хийнэ.





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв оргоо, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.07.09 № 1218  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БАГАНУУР ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ БАГАНУУР  
ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН  
НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Багануур дүүргийн Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Багануур дүүргийн Монгол Ардын намын хорооны Багануур дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн

37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Багануур дүүргийн Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Багануур дүүргийн сонгуулийн хороонд

Хавсралт: ... хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НОМИНБААТАР





**БАГАНУУР ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД БАГАНУУР ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН  
ХОРООНООС ОРОЛЦОХ 2020-2024 ОНЫ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Багануур дүүрэг нь эдийн засаг, эрх зүйн шинэ орчин бүрдсэн, иргэнээ дээдэлсэн, баялаг бүтээгчдээ дэмжсэн, үйлдвэрлэл хөгжсөн, амьдралын ая тухтай, амар тайван, байгальд ээлтэй, ил тод нээлттэй бие даасан хот болно.

**НЭГ. ЭДИЙН ЗАСАГ, ЭРХ ЗҮЙН ШИНЭ ОРЧИН БҮРДСЭН ХОТ**

**Эрх зүй, засаглалын чиглэлээр:**


- 1.1 Багануур дүүргийг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлаар санал асуулгыг зохион байгуулж Засгийн газарт уламжилж ажиллана.
- 1.2 Төр, захиргааны байгууллагаас гаргах шийдвэрт иргэдийн оролцоог хангаж ажиллана.
- 1.3 Багануур дүүргийг 2030 он хүртэл хөгжүүлэх 'Хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө'-г хэрэгжүүлж ажиллана.
- 1.4 Нээлттэй, хариуцлагатай засаглалын бодлого хэрэгжүүлж, нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд тавих хяналтыг тогтмолжуулж, ажлын уялдаа холбоог сайжруулна.
- 1.5 Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох үйл ажиллагааг ил тод байдлыг хангаж ажиллана.
- 1.6 Төрийн албыг мэргэшсэн, тогтвортой байдлыг хангаж, "Төрийн албан хаагчдын суриал, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр" хэрэгжүүлнэ.
- 1.7 Хороодоос иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, хэсгийн ахлагчдыг чадавхжуулах, хууль, эрхзүйн мэдлэг олгох сургалтыг тогтмол зохион байгуулж, төр, иргэний хамтын ажиллагааг сайжруулна.
- 1.8 Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

**Эдийн засаг, төсөв санхүүгийн чиглэлээр:**

- 1.9 Эдийн засгийн үр ашигтай гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж хамтран ажиллана.
- 1.10 Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлж, төсвийн орлогын бааз суурийг нэмэгдүүлнэ.
- 1.11 Төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг оновчтой болгож, төсвийн сахилга батыг сайжруулна.
- 1.12 Хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудад иргэдийн саналыг бүрэн тусгаж, төсөл арга хэмжээ, худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод болгож, гүйцэтгэлийн хяналтад иргэдийн оролцоог хангаж ажиллана.

**Хүрэх үр дүн:**

Бие даан хөгжих эдийн засаг, эрх зүйн шинэ орчин бүрдэж, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоо нэмэгдэн, төрийн үйлчилгээ иргэдэд цогц, хүртээмжтэйгээр хүрч, төсвийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналт сайжирч ил тод нээлттэй болно.



## ХОЁР. ИРГЭНЭЭ ДЭЭДЭЛСЭН ХОТ

### Эрүүл мэнд, биеийн тамирын чиглэлээр:

- 2.1 50 ортой төрөх эмнэлгийг ашиглалтад оруулж, иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэж, эх хүүхдийн эрүүл мэндэд онцгой анхаарч, оношлогоо эмчилгээний орчин үеийн тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар ханган төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.
- 2.2 Эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалт, цахим үйлчилгээг боловсронгуй болгож, эмч эмнэлгийн ажилчдыг ёс зүй, харьцаа хандлага болон мэргэжлийн ур чадварыг сайжруулах, гадаад дотоодын сургалтад хамруулан, нарийн мэргэжилтний эмч нарыг тогтвор суурьшилтай ажиллахыг дэмжих "Сайн эрүүл мэндийн мэргэжилтэн" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.
- 2.3 Нийгмийн эрүүл мэндийн төвийг бие даасан бүтэцтэй болгож, иргэдийг амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх зөв дадал хэвшилд сургах, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх оношлогооны төвтэй болно.
- 2.4 Өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох "Эрүүл шүд" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.5 "Сүрьеэгүй Багануур" дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж "Сүрьеэгүй дүүрэг" болох зорилт тавин ажиллана.
- 2.6 Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах, зөвлөгөө өгөх "Эрэгтэйчүүдийн кабинет"-ийг нээн ажиллуулна.
- 2.7 "Элэг бүтэн Монгол" хөтөлбөрийг үргэлжлүүлж, "Хавдрын эсрэг хамтдаа" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.8 Спортын клубуудын үйл ажиллагааг идэвхижүүлж, нэр төрлийг олшруулан үйл ажиллагааг дэмжиж, спортын холбоод, салбар зөвлөлүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- 2.9 Нийтийн бүжгийн төрлийг түлхүү хөгжүүлж дасгал хөдөлгөөнөөр хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ.
- 2.10 Дүүргийн гэр хорооллын алслагдсан хэсэгт Соёл, спортын төвийг байгуулна.

### Боловсрол, соёл, урлагийн чиглэлээр:

- 2.11 Боловсролын чанарын шинэчлэлийн хүрээнд сургуулийн өмнөх боловсрол, бага, суурь, бүрэн дунд боловсролын чанарыг сайжруулж, багш нарыг гадаад дотоодын сургалт, үйл ажиллагаанд хамруулж "Чадварлаг багш" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.12 Сургууль, цэцэрлэгийн гадна орчинг стандартын шаардлага хангасан спорт, амралтын талбайтай болгох бодлого хэрэгжүүлж ажиллана.
- 2.13 Ерөнхий боловсролын сургуулиудын суудлын тоог өсөн хэрэгцээнд тулгуурлан нэмэгдүүлэх бодлого барьж ажиллана.
- 2.14 Боловсролын салбарын багш, ажиллагсдын мэргэжил ур чадварыг дээшлүүлэх, урамшуулах, ажиллах нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.
- 2.15 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг байгуулж, төрөлжсөн нарийн мэргэжилтэнтэй ажиллах хүчнийг бэлтгэнэ.
- 2.16 Алслагдсан хэсэгт бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилгыг ашиглалтад оруулна.
- 2.17 Үдийн цай хөтөлбөрийг оргожүүлж үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.18 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг өргөжүүлж, сувиллын бүлэг нээн ажиллуулна.





### ГУРАВ. БАЯЛАГ БҮТЭЭГЧДЭЭ ДЭМЖСЭН, ҮЙЛДВЭРЛЭЛ ХӨГЖСӨН ХОТ

- 3.1 “Багануур үйлдвэрлэл, технологийн парк”-ийн ус сувагжуулалт, эрчим хүч, шугам сүлжээ бүхий дэд бүтцийг байгуулж, томоохон болон жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлнэ.
- 3.2 400МВт хүчин чадалтай дулааны цахилгаан станцыг ашиглалтад оруулж, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцлийг бүрдүүлнэ.
- 3.3 Багануурын уурхайн хүрэн нүүрсийг ашиглан жилд 30 мянган тонноос багагүй утаагүй түлшний үйлдвэр, хийн түлшний үйлдвэр байгуулах төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 3.4 Стандарт шаардлагад нийцсэн хөдөлмөр хамгааллын норм хувцасны оёдлын үйлдвэрийг бодлогоор дэмжиж, хувийн хэвшлийн салбартай хамтран ажиллана.
- 3.5 Ахуйн үйлчилгээний салбарт ажиллагсдын мэргэшил мэдлэгийг дээшлүүлж, орчин нөхцөлийг сайжруулна.
- 3.6 Орчин үеийн шаардлагад нийцсэн Худалдааны төв байгуулах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- 3.7 Жимс, жимсгэнэ, хүнсний нарийн ногоо тариалалт эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжих замаар өвлийн хүлэмжийг бий болгоно.
- 3.8 Малчин тариаланчдын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлыг шийдвэрлэх үндэсний бүхий л хөтөлбөрийг дүүрэгт хэрэгжүүлнэ.
- 3.9 Малын үйлдвэр угсааг сайжруулах, малаас гарах ашиг шимийг нэмэгдүүлэх талаар бодлого барьж ажиллана.
- 3.10 Хүнсний аюулгүй байдлыг хангах итгэмжлэгдсэн лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж, эрсдлээс сэргийлнэ.
- 3.11 Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг бий болгох нарны цахилгаан станцын төслийг эрчимжүүлнэ.

#### Хүрэх үр дүн:

*Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд бизнесийн таатай орчин бүрдэж, төр хувийн хэвшлийн түншлэл болон гадаадын хөрөнгө оруулалт, тогтвортой ажлын байр нэмэгдэн, эдийн засгийн чадавх сайжирч, хүнсний аюулгүй байдал хангагдана.*

### ДӨРӨВ: АМЬДРАЛЫН АЯ ТУХТАЙ, АМАР ТАЙВАН ХОТ

- 4.1 “Нэг хот-Нэг стандарт” хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.
- 4.2 Орлогод нийцсэн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлж, амины болон нийтийн орон сууцнуудыг шинээр ашиглалтад оруулж, иргэдийг орон сууцаар хангах бодлого хэрэгжүүлнэ.
- 4.3 Гэр хорооллуудад цэвэр, бохир ус, халаалтын хэсэгчилсэн инженерийн байгууламж барьж, цахилгаанд бүрэн холбож, гудамж зам талбайг иж бүрэн гэрэлтүүлэгтэй болгож, хуучны орон сууцны байруудын дээвэр, орцны засвар, гадна фасадыг дулаалж, өнгө үзэмжийг сайжруулна.
- 4.4 Дүүргийн үерийн усны шугам сүлжээг шинэчилж, өргөтгөнө.
- 4.5 Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор авто замын уулзвар, гарцыг өргөтгөх, шинээр автозам тавих, гэр хороололын замын байгууламжыг сайжруулах, уулзвар хэсэгт стандартын шаардлага хангасан гэрлэн дохиотой болгоно.
- 4.6 Гэр болон орон сууцны хорооллын хяналтын камерын тоог нэмэгдүүлж иргэдийн аюулгүй байдлыг хангана.
- 4.7 Иргэдийн амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх зам талбай, ногоон байгууламж бүхий хүүхдийн тоглоомын талбайг орон сууц, гэр хороололд нэмэгдүүлнэ.
- 4.8 Иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх ая тухтай орчин бүрдүүлэх замаар цэцэрлэгт хүрээлэн байгуулна.



- 4.9 Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмж, соёлыг дээшлүүлж цахилгаан тээврийг нэвтрүүлнэ.
- 4.10 Дүүргийн 5 дугаар хорооны Залуус хэсэгт дахин тололтолт хийж замаар 500 аас доошгүй айлын орон сууцны хорооллыг бий болгоно.
- 4.11 Орчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх, алдагдлыг бууруулах, шинэ техник технологи нэвтрүүлэх чиглэлээр төслийг хэрэгжүүлж, айл өрхийн цахилгаан хангамжийн асуудлыг иж бүрэн шийдвэрлэнэ.
- 4.12 Гамшиг осол, галын аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, мэргэжлийн байгууллагуудын ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.
- 4.13 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг татан оролцуулж, эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.
- 4.14 Архи, согтууруулах ундаа, тамхи худалдан борлуулахад тавих хяналтыг эрчимжүүлж, архи, тамхигүй орчинг бий болгох санал санаачилгыг дэмжинэ.
- 4.15 Гэрч хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах "Хамгаалах байр"-ыг бий болгоно.
- 4.16 Батлан хамгаалах төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжид холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

**Хүрэх үр дүн:**

*Иргэдийн аюулгүй, амар тайван ажиллаж амьдрах таатай орчин нөхцөл бүрдэж, төр иргэний хамтын ажиллагаа сайжирна.*

**ТАВ. БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ НОГООН ХОТ**

- 5.1 Нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг 30м<sup>2</sup>-д хүргэнэ.
- 5.2 Утаагүй түлшийг нэвтрүүлж, агаар орчны бохирдлыг 80%-иар бууруулж, төв хогийн цэг шинээр байгуулна.
- 5.3 Гэр хорооллын айл өрхийн цахилгаан эрчим хүчний шөнийн хэрэглээний үнийг тэглэх ажлыг үргэлжлүүлнэ.
- 5.4 Гэр хорооллын айл өрхийн зөөврийн усан сангийн эрүүл аюулгүй орчинг бүрдүүлж, цэвэр усны хангамжийг нэмэгдүүлнэ.
- 5.5 Хэрлэн гол бусад гол горхи, булаг шандны эх, ойн сан бүхий газрыг хамгаалах, нөхөн сэргээх бодлого боловсруулан иргэд, төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 5.6 Хөрс, ус, агаарын хяналт шинжилгээний чадавхыг бэхжүүлж, байгаль орчны мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, олон нийтэд хүргэх мэдээллийг сайжруулна.
- 5.7 Төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын найдвартай ажиллагааг хангана.

**Хүрэх үр дүн:**

*Нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдэн, байгаль орчны бохирдол буурч, иргэд эрүүл, эко орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.*

5 бүлэг, 81 заалт





**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г Амгын гудамж, Снплын тав өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.07.10 № 1257

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
БАЯНГОЛ ДҮҮРГИЙН МОНГОЛ  
АРДЫН НАМЫН ХОРООНД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Баянгол дүүргийн Монгол Ардын намын хорооноос ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа-2050”, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Баянгол дүүргийн Монгол ардын намын хорооноос дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн

37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баянгол дүүргийн Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /6. хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Баянгол дүүргийн сонгуулийн хороонд

Хавсралт: 6. хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НОМИНБААТАР





БАЯНГОЛ ДҮҮРГИЙН  
МОНГОЛ АРДЫН НАМ

# ШИНЭ БАЯНГОЛ

ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ **МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020 оны 6-р сар  
Улаанбаатар хот

Бид ингэж шинэчилнэ:

1. Хүүхдэд ээлтэй Баянгол
2. Залуучуудаа дэмжсэн Баянгол
3. Ахмадад ачлалтай Баянгол
4. Эрүүл, боловсролтой Баянгол
5. Энх саруул, аюулгүй, тухтай Баянгол
6. Жижиг, дунд бизнесийн төв-Баянгол
7. Цахим Баянгол
8. Шинэчлэгдсэн Баянгол



## 1. Хүүхдэд ээлтэй Баянгол


1. Эх орны ирээдүй болсон хүүхдүүдээ болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дүүрэг, олон нийт, аж ахуйн нэгжүүд хүүхдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, “Баянгол-Хүүхэд хэрэглэгч” хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж, хамтын ажиллагаа, нийгмийн түншлэлийг дэмжсэн хүүхдэд ээлтэй жишиг дүүрэг болгоно.
2. Хүүхэд хөгжлийн олон төрөлт төв байгуулж, өдөр өнжүүлэх төвүүдийг бодлогоор дэмжинэ.
3. Хүүхдийн цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
4. Хүүхдийн тоглоомын болон спортын талбайг олон улсын стандартад нийцүүлэн байгуулна.
5. Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, хүүхэд олноор зорчих хэсгийг гарц, гэрлэн дохио, хурд сааруулагч камертай болгоно.
6. Сургууль, цэцэрлэгийн гадаа талбайг хичээлийн бус цагаар хүүхэд залуусын чөлөөт цагаа өнгөрүүлэх боломжоор хангаж, иргэдэд нээлттэй болгоно.
7. Хөгжлийн онцлогтой хүүхдийг өдрөөр болон урт хугацаанд үйлчилгээ үзүүлэх төвийг байгуулна.
8. Байгууллагын ажилчдын хүүхдийн цэцэрлэгийг дэмжинэ.

## 2. Залуучуудаа дэмжсэн Баянгол

1. Залуу гэр бүлийн эрүүл мэнд, боловсрол, ходелмор орхлолт, нийгмийн харилцаа сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжсэн “Залуу гэр бүл” төсөл хэрэгжүүлнэ.
2. Залуу гэр бүлийн түрээсийн орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
3. Залуучуудын хөгжлийг дэмжих төвийг байгуулна.
4. Хүүхэд залуучууд өсвөр үеийнхнийг гадны сөрөг нөлөө, бусдын дарамт, гэмт хэрэгт өртөх, мансууруулах бодис хэрэглэхээс сэргийлэх, цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
5. Гэр бүл, хүүхэд, оюутан, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орчин бий болгоход зориулсан төвүүд байгуулна.
6. Асрамжийн газарт өсөж, 18 нас хүрсэн залуучуудыг бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх төсөл хэрэгжүүлнэ.
7. “Тогтвортой амар амгалан гэр бүл” үндэсний хөтөлбөрийг үе шаттайгаар дүүрэгтээ хэрэгжүүлнэ.
8. “Цалинтай ээж” хөтөлбөрийг үргэлжлүүлж, 3 хүртэлх насны эхчүүдэд ялгаваргүй хамруулна.

## 3. Ахмадад ачлалтай Баянгол

1. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
2. Ахмадын эрүүл мэндийн үйлчилгээг гэрт нь хүргэнэ.
3. Ахмадуудын мэргэжлийн холбоодыг байгуулж, дүүрэг хороодтой хамтарч ажиллана.
4. Ахмадын чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлэх, мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлэх хөгжлийн төвүүдийг нэмж байгуулна.



5. Ахмадын нийтийн тээвэр, амралт сувиллын хөнгөлөлт, хүнсний талон зэрэг тусламж үйлчилгээний зардлыг хувь хүний тэтгэврийн дансанд шилжүүлэх тогтолцоог бий болгоно.
6. Сонирхлын бүлэг, клубуудыг байгуулж, ахмадуудыг хамруулан дэмжиж хамтран ажиллана.

#### **4. Эрүүл, боловсролтой Баянгол**

1. Өрхийн эмнэлгийг түшиглэсэн оношилгоо шинжилгээний 4 төв байгуулна.
2. Өрхийн эмнэлэггүй 23, 24, 25-р хороодод шинээр байгуулна.
3. 9, 10, 14, 18-р хороодод өрхийн эмнэлгийг байртай болгоно.
4. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэгт бүх иргэдийг хамруулна.
5. Анхан шатны тусламж үйлчилгээг өрхөд хүргэнэ. Эмнэлэгийн үйлчилгээний төвлөрлийг сааруулж, эмнэлэгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.
6. Сургууль, цэцэрлэггүй хороодод сургууль, цэцэрлэгтэй болгоно.
7. Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн дуусаагүй барилгуудыг ашиглалтанд оруулна.
8. Дүүргийн хэмжээнд нийтийн номын сан байгуулна.
9. Дүүргийн залуучуудыг барилга болон төмөр замын мэргэжлээр мэргэжлийн сургуульд сургах, ажлын байртай болгохыг бодлогоор дэмжинэ.
10. Кембриджийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн тоог нэмэгдүүлнэ.
11. УБТЗ ХНН-тэй хамтран 3, 4-р хорооны ерөнхий боловсролын сургуулиуд дээр төмөр замын мэргэжлийн лицей анги нээж хичээллүүлнэ.
12. Бүх нийтийн эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгийг тогтмолжуулж, хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

#### **5. Энх саруул, аюулгүй, тухтай Баянгол**

1. Орчин үеийн хотын стандартыг нэвтрүүлж мөрдүүлнэ.
2. Энхтайваны өргөн чөлөөний төв зам дагуу 10-р хороолол 5, 6, 25-р хороонд нүхэн болон гүүрэн гарц барьж замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулна.
3. Л.Энэбишийн өргөн чөлөөнөөс троллейбусын эцсийн буудал хүртэлх замын голын хэсгийг газар доорх байгууламжийн системд шилжүүлнэ.
4. Алслагдсан гэр хорооллыг цахилгаанд бүрэн холбож, гудамж талбайг иж бүрэн гэрэлтүүлэгтэй болгоно.
5. Мэргэжлийн цэцэрлэгжүүлэгчдийг бэлтгэж, бүх хороодод цэцэрлэгжүүлэх аяныг өрнүүлнэ.
6. Агаар, хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор мод, бут, сөөг тариалах ажлыг нөхөрлөлийн хэлбэрээр дэмжиж ажиллана.
7. Орон сууцны зориулалтаар газрын зөвшөөрөл шинээр олгохгүй.
8. 14-р хорооны нутаг дэвсгэрт Ю.Цэдэнбалын нэрэмжит ногоон байгууламж, хүүхдийн тоглоомтой цэцэрлэгт хүрээлэнг байгуулна.
9. ТҮК-ийн ажилтнуудын амрах байрыг байгуулна.
10. Нийтийн эзэмшлийн талбай, орц гарцыг цэгцэлж, талбайн гэрэлтүүлэг, камерын тоо болон ногоон байгууламжийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ.




11. 10-р хороонд тав тухтай, орчин үеийн шийдэл бүхий амралтын бүс “Баянгол цэцэрлэгт хүрээлэн”-г байгуулна.
12. Иргэд оршин суугаа байр, хотхон, гудамжиндаа тохижилт хийх санаачилгыг дэмжин хамтран ажиллана.

## **6. Жижиг, дунд бизнесийн төв Баянгол**

1. Жижиг дунд бизнесийг хөгжүүлэх орчныг сайжруулах, бизнес эрхлэхэд учирч буй хүндрэл бэрхшээлийг арилгахад анхаарч төрийн байгууллагуудтай хамтран ажиллана.
2. “Баянгол хөгжлийн сан” байгуулж, иргэдийн нэгдэж хоршин үйлдвэрлэл болон хамтран бизнес эрхлэхэд бодлогоор дэмжлэг үзүүлнэ.
3. Гарааны бизнес /Start up/ эрхлэгчдийн зөвлөгөө, мэдээлэл, хамтын ажиллагааны төвийг байгуулна.
4. Баянголын бизнес эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний борлуулалтын нэгдсэн сүлжээг бий болгоно. Баянголд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, татвар, санхүүгийн зөвлөгөө өгөх, Олон Улсын үзэсгэлэн худалдаанд оролцуулах, кластерийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
5. Баянгол дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй томоохон ААН-үүд өөрийн дүүргийн жижиг дунд үйлдвэрлэгчдээс худалдан авалт хийдэг болох бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
6. 3, 4-р хорооллын өргөн чөлөөг худалдаа, үйлчилгээний төрөлжсөн гудамж болгоно.
7. Жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгчдэд ажлын байр нэмэгдүүлэх бодлогыг баримталж ажиллана.
8. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд тоног төхөөрөмжийг лизингээр өгөх механизмыг бий болгоно.
9. Импортыг орлох бараа бүтээгдэхүүнийг дотоодод үйлдвэрлэдэг баялаг бүтээгчдийг төрийн худалдан авалтаар дэмжинэ.
10. Орлого багатай өрхийн насанд хүрээгүй гишүүдийг мэргэжил эзэмшүүлэх ур чадварыг ахиулах сургалтанд хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
11. Онлайн орчинд ажиллах ажлын байрыг нэмэгдүүлнэ.

## **7. Цахим Баянгол**

1. Хүнд сурталгүй төрийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор төрийн байгууллагуудын үйлчилгээг сайжруулж, төрийн албан хаагчдыг чадавхижуулан төсвийн зардлыг хэмнэнэ.
2. “Цахим Баянгол” хөтөлбөрийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг цахим болгон, иргэддээ хүндрэл чирэгдэлгүй, ээлтэй болгоно.
3. “Нээлттэй Баянгол” хөтөлбөрийг хэрэгжүүлж, төрийн үйл ажиллагаанд цахим шилжилтийг бүрэн нэвтрүүлж, төрийн албыг нээлттэй ил тод, хүртээмжтэй болгоно.
4. “Цахим боловсрол” хотолборийг дүүргийн бүх ЕБС-ын сургуульд хэрэгжүүлж, сургалтын чанарыг дээшлүүлж, Олон Улсын хөтөлбөрт онлайнгаар хамрагдах боломжийг бүрдүүлнэ.
5. “Цахим эрүүл мэнд” хөтөлбөрийг дүүргийн эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлгүүдэд хэрэгжүүлнэ.
6. “Засаг дарга сонсож байна” иргэдтэй харилцах нээлттэй төвийг тогтмол ажиллуулна.




7. Цахим орчинд байгууллагуудын харилцан холбоог сайжруулж, цахим удирдлагыг бий болгоно.
8. Иргэдийн оролцоог хангах, соён гэгээрүүлэх зорилгоор “Коммунити центр” байгуулна.

## 8. Шинэчлэгдсэн Баянгол

1. Төмөр замын дээд сургуулийн өмнөх талбайг “Төмөр замчдын нэрэмжит талбай” болгон шинээр байгуулна.
2. Хуучин орон сууцыг дулаалах болон орон сууцны дээврийн шинэчлэлтийн ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Мөн орон сууцны ашиглалтын хугацаа дууссан, эвдэрсэн хуучин цахилгаан шатуудыг бүрэн шинэчилнэ.
3. Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх хэлбэрээр иргэдийг орон сууцжуулна.
4. Иргэдийг ипотекийн зээлийн хөтөлбөрт хамруулна.
5. Газар доорх инженерийн байгууламжийг хонгилын системд шилжүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
6. Нэгдсэн давхар граж, авто зогсоолын тоог нэмэгдүүлнэ.
7. 2, 3, 20-р хорооны хуучин орон сууцыг дахин төлөвлөлтөд үе шаттай хамруулна.
8. 9, 24, 25-р хороонд хорооны цогцолбор байгуулна.
9. Сууц өмчлөгч холбоодын үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллана.
10. Гэр хорооллыг сургууль, цэцэрлэгтэй болгоно.
11. Гандан орчмыг Улаанбаатар хотын аялал жуулчлал, үндэсний соёлын төв хэсэг болгон хөгжүүлнэ.
12. Гэр хороололд инженерийн дэд бүтэц бүхий “Сервис центр”-ийг 11, 22-р хороодод байгуулна.
13. Гэр хорооллын замуудыг хатуу хучилттай болгож, тоосжилтыг 50%-иар бууруулна.
14. Гэр хороололд инженерийн иж бүрэн дэд бүтэц бүхий амины орон сууцны жишиг хороолол байгуулна.
15. Хогийг ангилан ялгах соёлыг хэвшүүлж, хогны дэвшилтэд менежмент хэрэгжүүлнэ.
16. Гэр хорооллын айл өрхийг үнс түр хадгалах зориулалтын савтай болгож, үнсийг дахин боловсруулах үйлдвэр байгуулна.
17. Хороодын худгийг смарт болгож 6 хороонд шинээр цэвэр усны худаг барина.
18. Халаалтын зуухнуудыг үе шаттайгаар буулгаж, хэрэглэгчдийг төвлөрсөн болон хэсэгчилсэн эх үүсвэрт холбоно.

--- оОо ---





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.07.09 № 1242  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ БАЯНЗҮРХ  
ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН  
НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Баянзүрх дүүргийн Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Баянзүрх дүүргийн Монгол Ардын намын хорооны Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн


иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баянзүрх дүүргийн Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /!!/ хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Баянзүрх дүүргийн сонгуулийн хороонд

Хавсралт: /!!/ хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР



Баянзүрх дүүргийн Монгол  
Ардын Намын тэргүүлэгчдийн 2020  
оны 07 сарын 07 ны өдрийн  
хуралдаанаар батлав.

## БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020 он

Монгол Ардын Нам нь 1921 оны 3 сарын 1-нд байгуулагдсан Монголын хамгийн том улс төрийн ууган хүчин<sup>1</sup> бөгөөд аймаг, нийслэл, дүүрэг тус бүрд намын хороодыг байгуулж тулгамдсан асуудлуудын шийдлийг олохоор зохион байгуулалттайгаар хэлэлцэж, ажиллаж ирсэн. Баянзүрх дүүргийн Монгол ардын намын хороо /цаашид “намын хороо” гэх/ нь тус намын томоохон нэгж болно.

Баянзүрх дүүрэг /Цаашид “дүүрэг” гэх/ нь нийслэлийн хамгийн том дүүрэг бөгөөд 1965 онд анх байгуулагдаж<sup>2</sup> 1992 оны УИХ-ын 18 тоот тогтоолоор Баянзүрх хайрханаараа овоглож “Баянзүрх дүүрэг” нэртэй болсон<sup>3</sup> байдаг. Өдгөө засаг захиргааны нэгж болох 28 хороотой, 104700 өрх, 361500 гаруй хүн амтай. Тус дүүрэгт Монгол улсын нийт хүн амын 10,6 хувь, Улаанбаатар хотын нийт хүн амын 23 хувь нь оршин сууж байна. Байршлын хувьд хотын зүүн өмнөд хэсэгт оршдог ба улсын 43 цэцэрлэг, 30 дунд сургууль тус дүүрэгт үйл ажиллагаагаа явуулж байна. Баянзүрх дүүргийн нийт хүн амын 35,9 хувь нь 0-18 насны хүүхдүүд, 27,7 хувь нь 19-35 насны залуучууд, 30.2 хувь нь 36-59 насны иргэд, 6,2 хувийг 60-аас дээш насны иргэд байна.

Намын хорооноос боловсруулсан энэхүү мөрийн хөтөлбөр нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37.5 дахь хэсэгт заасны дагуу дараах хууль тогтоомжид нийцсэн болно. Үүнд:

### 1. Хөгжил бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хувьд:

Хөгжил Бодлого Төлөвлөлтийн тухай хуулийн хуулийн 5 дугаар зүйлд тусгасан Хөгжлийн бодлого төлөвлөлтөд баримтлах зарчмуудад бүрэн нийцсэн. Мөн тус хуулийн 15 дугаар зүйлд тусгасан Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг

<sup>1</sup>[https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB\\_%D0%90%D1%80%D0%B4%D1%8B%D0%BD\\_%D0%9D%D0%B0%D0%BC](https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB_%D0%90%D1%80%D0%B4%D1%8B%D0%BD_%D0%9D%D0%B0%D0%BC)

<sup>2</sup><https://mn.wikipedia.org/wiki/%D0%91%D0%B0%D1%8F%D0%BD%D0%B7%D2%AF%D1%80%D1%85>

<sup>3</sup><https://zasag.mn/m/bzd/intro>

Handwritten signatures and a red stamp are present at the bottom right of the page.

даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөр болох бүсчилсэн хөгжлийн бодлого, аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилттой уялдсан байх ба тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн дунд хугацааны эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын чиглэл, түүнд хүрэх зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, төсөв, санхүүгийн эх үүсвэр, шалгуур үзүүлэлтийг энэхүү мөрийн хөтөлбөр тодорхойлсон юм.

## **2. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн хувьд:**

1994 онд батлагдсан Нийслэлийн Эрх Зүйн Байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан Нийслэлийг хотын нийгэм соёлын амьдралын бүхий л хүрээнд тэргүүлэх байр суурь эзлэх нөхцөлийг бүрдүүлэхэд шаардагдах хот байгуулалт, нийгэм, эдийн засаг, байгаль орчны зохистой тэнцлийг хангах бодлогод дүйцүүлж энэхүү мөрийн хөтөлбөрийг боловсруулсан.

## **3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн хувьд:**


Энэхүү мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь 2020 онд батлагдсан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасанчлан Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн бөгөөд санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг хангасан юм.

Мөрийн хөтөлбөр нь Монгол улсын болон нийслэл дүүргийн хөгжлийн асуудлаар боловсруулсан дараах баримт бичгүүдэд нийцсэн. Үүнд:

### **1. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хувьд:**

Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг Монгол Улсын Ерөнхий сайдын 52 дугаар захирамж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 65 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын дэд хэсэг, яам, агентлаг, эрдэмтэн судлаачдын оролцоотойгоор боловсруулсныг Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхэд өргөн барьсан. Энэхүү Монгол Улсын Урт Хугацааны хөгжлийн бодлогод төлөвлөсөн Хүний хөгжил бүлэгт хамаарах боловсрол, хүнд ээлтэй амьдрах орчин, хөдөлмөрийн зах зээл болон нийгмийн хамгааллын бодлогууд зэргийг удирдлага болгон энэхүү мөрийн хөтөлбөрийг боловсруулсан.

### **2. Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын хувьд:**



Нийслэлийн ИТХ-ын ээлжит XXXII хуралдаанаар “Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт”-ыг хэлэлцэн, батлагдсан бөгөөд уг зорилтыг Монгол улсыг хөгжүүлэх 2050 бодлоготой уялдуулан хүн төвтэй хот байхаар дөрвөн чиглэл бүхий төсөл боловсруулсан. Энэ хүрээнд ядуурлыг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх, боловсрол эзэмшилтийг нэмэгдүүлэх, орчин төвтэй шийдэл хүрээнд эко хот байгуулж, хүнсний хог хаягдлын хэмжээг бууруулах, ногоон байгууламжуудыг нэмэгдүүлэх зэрэг ажлыг цогцоор нь хийхээр төлөвлөсөн ба энэхүү мөрийн хөтөлбөр нь энэхүү зорилтод нийцүүлж боловсруулагдсан юм. Мөн Нийслэлийн Засаг даргын тамгын газрын зүгээс Улаанбаатар хотыг 2020-2040 оны хооронд хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан Засгийн газраар батлуулах шатанд байгаа бөгөөд энэхүү төлөвлөлтийн төслийн үзэл санааг баримталсан болно.


Мөрийн хөтөлбөрийг боловсруулахад Эдийн засгийн бодлого өрсөлдөх чадварын судалгааны хүрээлэнгээс 2019 онд гаргасан Дүүргүүдийн өрсөлдөх чадварын судалгаа, Нийслэлийн статистикийн газраас гаргасан Баянзүрх дүүргийн 2018 оны жилийн эмхтгэл /2019 оны 10-р сард нэгтгэгдсэн дүн бөгөөд 2019 оны дүн гараагүй байгаа тул энэхүү статистикийн ашиглав./, мөн тус газраас гаргасан Баянзүрх дүүргийн 2020 оны 04-р сарын статистикийн танилцуулгыг ашигласан.

Мөрийн хөтөлбөр нь дүүргийн удирдлагыг 8 жил хэрэгжүүлсэн өнөөгийн удирдлагуудын алдаатай, иргэддээ чиглээгүй, хүнд сурталжсан бодлогыг халж, үр нөлөөтэй, гүйцэтгэлтэй, иргэддээ чиглэсэн бодлого хэрэгжүүлэх багийг сонгож өнөөдрийн амьдралын нөхцлөө сайжруулах агуулгаар “**САЙЖРУУЛААД САЙХАН АМЬДАРЬЯ**” уриаг дэвшүүлсэн болно.

Мөрийн хөтөлбөр нь нийт 8 чиглэлд 52 зорилтуудыг дэвшүүлсэн болно.  
Үүнд:

### **Чиглэл 1: Ажиллаж, бизнес эрхлэхэд таатай дүүрэг**

Баянзүрх дүүргийн хэмжээнд 2018 онд 224134 хөдөлмөрийн насны иргэд байгаагаас ажиллагчдын тоо 140347, бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 8091 байсан бол эдгээрээс бусад иргэд нь албан бус салбарт ажиллах эсхүл бүртгэлгүй ажилгүй иргэд болоод байна. Дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 49.9 хувьтай байгаа нь улсын хэмжээнд хангалтгүй үзүүлэлт юм. Дүүрэгт 28000 орчим аж ахуй нэгж бүртгэлтэй байгаагийн 13000 орчим нь үйл ажиллагаагаа явуулж байна. Цаашид дүүргийн иргэдийн амьдралын чанарыг сайжруулж, хүрэлцэхүйц цалин хөлстэй, баталгаатай ажлын байртай, бизнес аж ахуй эрхлэхэд саад бэрхшээлгүй төдийгүй, дэмжлэг туслалцаатай байх нөхцлийг бүрдүүлнэ. Улсын хэмжээнд ажил эрхлэлт, дундаж орлого, шинэ бизнес эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэг, нийт бизнес эрхлэгчдээ дэмжих үзүүлэлтээрээ тэргүүлэх дүүрэг болно.




A red rectangular official stamp is located at the bottom right of the page. Inside the stamp, there are four vertical columns of Mongolian text. Below the stamp, there is a handwritten signature in black ink.

1. Бизнес эрхлэгчдэд таатай дүүрэг болно. Дүүргийн хэмжээнд бизнес эрхлэгчидтэй ажилладаг төрийн байгууллагуудын үйлчилгээний хурдыг 2 дахин нэмэгдүүлж, зөвлөн туслах, дэмжлэг үзүүлэх, аливаа алдаа дутагдлыг хамтран засч залруулахад анхаарч ажиллана. Төрийн бүх төрлийн үйлчилгээг ил тод нээлттэй болгож, бизнес эрхлэгчдэд дүүргээс нэгдсэн байдлаар мэдээлэл өгөх хөтөч, мэдээлэгчийн тогтолцоог бүрдүүлнэ. Ажлын байр нэмэгдүүлсэн, шинээр ажилтан авсан байгууллагуудыг байнга зарлан мэдээлж, дүүргийн эрх хэмжээний хүрээнд бүхий л боломжит хэлбэрээр дэмжин ажиллана.
2. Дүүргийн татварын хэлтэс, нийгмийн даатгалын хэлтэс, санхүү төрийн сангийн хэлтэс, үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс, мэргэжлийн хяналтын хэлтэс зэрэг бизнес эрхлэгчидтэй нягт хамтран ажилладаг хэлтсүүдийн үйлчилгээг хүнд сурталжсан бус, хөгжиж дэвшихэд нь хамтран ажилладаг соёлыг бий болгоно.
3. Entrepreneur-уудыг дэмжигч, Start up дүүрэг болно. Шинээр бизнес эрхлэхээр зорьж буй залуу бизнес эрхлэгч, шинэ санаатнуудыг сургах, компаниа байгуулах, санаагаа бодит бизнес болгох, хөрөнгө оруулалт татахад дэмжих төрийн байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн хамтарсан зөвлөлийг байгуулж ажиллана. 4 жилийн хугацаанд хувийн хэвшлүүдтэй хамтрах замаар нийт 1000 старт-ап компанийг дэмжиж, боломжит бизнес болгон ажиллаж, эдгээр компаниудад 10000-аас дээш тооны залуучуудыг ажиллах боломж нөхцлөөр хангаж, залуучуудаа санхүүгийн бодит эрх чөлөөнд хүрэхэд дэмжлэг үзүүлнэ.
4. Дүүрэг нь Улаанбаатар хотын худалдаа үйлчилгээний томоохон төвүүд олонтой бөгөөд нийт 83 бөөний болон худалдааны төв, захууд үйл ажиллагаа явуулдаг. Мөн 1067 дэлгүүр, 228 түц, 193 гутлын болон авто засвар ажиллаж байгааг цаашид стандартын шаардлага хангасан байдлаар ажиллахад дэмжлэг үзүүлж, иргэдийг чанартай, сайн үйлчилгээтэй, хямд үнэтэй бүтээгдэхүүнээр хангахад анхаарч ажиллана. Үйлчилгээний салбарт ажиллаж байгаа иргэдийн эрхийг тууштай хамгаалж хаах, буулгах, хөөх, бус ажлын байрыг баталгаажуулах, ажиллах орчныг сайжруулах чиглэлд тууштай дэмжлэг үзүүлнэ.
5. Дүүргийн нийт ажил эрхэлж буй иргэдийн дундаж орлогын үзүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлд Засгийн газар болон нийслэлийн захиргаатай хамтран ажиллаж, тасралтгүй нэмэгдүүлэх боломжуудыг судалж ажиллана.

## **Чиглэл 2: Боловсрол эзэмших, хөгжихөд таатай дүүрэг**

Дүүргийн өрсөлдөх чадварын гол нөөц нь мэдлэг чадвартай, бүтээлч, ёс зүйтэй иргэн юм. Ийм иргэдийг бэлтгэн төлөвшүүлэхэд албан боловсролын салбарын материаллаг бааз хүний нөөц, чадавхийг бэхжүүлж, мөн ажлын байран



дээрээ иргэд чадваржих хөгжих бололцоог бүрдүүлэх хэрэгтэй. Тиймээс цэцэрлэг, сургуулийн насны хүүхдүүдийн сургууль цэцэрлэгт хамрагдах хүртээмжийг нэмэгдүүлэх, сургалтын чанарыг сайжруулж улсын хэмжээнд боловсролын чанарын үзүүлэлтээр тэргүүлэх дүүрэг болох, сургууль, цэцэрлэгийн байгууламжуудыг их хэмжээгээр нэмэгдүүлнэ.

1. Дүүргийн 28 хороо тус бүрт хүрэлцээтэй төрийн өмчийн цэцэрлэгтэй болгох зорилтыг хэрэгжүүлнэ. Ингэхдээ хүүхэд өөрийн амьдарч буй орчноосоо аль болох ойрхон цэцэрлэгтээ очих боломжийг хангасан стандартыг үе шаттайгаар нэвтрүүлнэ.
2. Сургуулийн тоог алслагдсан хороо тус бүрт нэмэгдүүлж, нийт сургуулиудын газрыг хамгаалалтанд авч, гадна талбай, биеийн тамир спортын талбайг тохижуулж, өргөжүүлнэ.
3. Дүүргийн хэмжээнд төрийн өмчийн сургуульд 3318, төрийн өмчийн цэцэрлэгт 1150 багш ажиллаж байгаа бөгөөд хувийн хэвшилд түүнээс их тооны багш нар ажиллаж байна. Эдгээр багш нарын өрсөлдөх чадвар, гадаад хэлний мэдлэгийг шат дараатайгаар дээшлүүлж сургалтын чанарыг бодитойгоор сайжруулна.
4. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад ажлын байран дээрээ шинэ ур чадварт суралцах хөтөлбөрийг хэрэгжүүлж аливаа хүн шинэ ур чадваруудад ажиллахын зэрэгцээ суралцах боломжийг бүрдүүлнэ.
5. Ахмад настнууд өөрийн туршлагыг дамжуулах, залуу үеэ сурган бэлтгэх боломжийг хангах MENTOR /Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч/ хөтөлбөрийг хэрэгжүүлж, ахмад болон залуу үеийн хэлхээ холбоо, харилцан суралцах боломжийг олгоно.
6. Нийслэлийн захиргаанаас хэрэгжүүлж буй 10000 мэдээллийн технологийн инженер бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд дүүргийн залуучуудыг хөтөлбөрт хамруулж мэдээллийн технологийн инженерээр бэлтгэнэ.

### Чиглэл 3: Эрүүл амьдрахад таатай дүүрэг

Дүүргийн нийт иргэдийн хамгийн чухал асуудлуудын нэг нь эрүүл мэнд юм. Иргэд нь эрүүл чийрэг, амьдралын зөв дадал хэвшилтэй, өвдсөн үед чанарын шаардлагад нийцсэн эрүүл мэндийн үйлчилгээ авдаг тогтолцоог бүрдүүлэх зорилттой ажиллана.

1. Дүүрэг нь одоогоор нэг ч улсын эмнэлэггүй байгаа нь иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад сөрөг нөлөөтэй байгаа тул ДҮҮРГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ /300+ ор бүхий/-ийг байгуулан ашиглалтад оруулна.
2. Дүүргийн Сүрьеэгийн диспансерын байрыг шинэчилж, нийгмийн эрүүл мэндийн төв байгуулна.




3. Дүүргийн нийт иргэдийг жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт эрүүл мэндийн даатгалаа хамрагдаж, шаардлагатай үйлчилгээ, зөвлөгөөг авах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Ингэхдээ ажил эрхэлж буй иргэд амралтын өдрөөрөө эсхүл ажлын бус цагаар энэхүү үйлчилгээг авах боломжоор хангана.
4. Дүүрэг нь Улаанбаатар хотын зүүн бүсийг бүхэлд нь хамардаг бөгөөд газар нутаг болон хүн амын 25-аас илүү хувийг эзлэн оршиж байна. Гэтэл уг бүсэд яаралтай түргэн тусламжийн төв байхгүй байгаа нь эрүүл мэндийн түргэн тусламжийн үйлчилгээний чанарыг бууруулах гол үзүүлэлт болж байна. Тиймээс зүүн бүсийн яаралтай түргэн тусламжийн төвийг байгуулж, дүүргийн иргэдэд түргэн тусламжийн үйлчилгээг ойртуулна.
5. 0-1 насны хүүхдийн эндэгдэл 2018 онд 32 байсан бөгөөд энэ үзүүлэлтийг 10 дахин бууруулж улмаар хүүхдийн эндэгдлийг хамгийн бага түвшинд хүргэх зорилтыг дэвшүүлэн үе шаттай хэрэгжүүлнэ. Мөн хүүхдийн эрүүл, эсэн мэнд амьдарч бойжих нөхцлийн талаарх суурь судалгааг хийж, эрсдэлт хүчин зүйлүүдийг бууруулан ажиллана.
6. Дүүргийн нийт хүн амын 6 хувийг ахмад настнууд эзэлж байгаа бөгөөд эдгээр ахмад настнуудад чиглэн ажиллах олон улсын стандартад нийцсэн ахмадын асрамжийн газар, байнгын асаргаатай хүнд хэлбэрийн тусгай хэрэгцээтэй хүүхэд, насанд хүрэгчдийн асрамжийн төв, ахмадын соёл, эрүүл мэндийн төв байгуулна.
7. Архидалтгүй дүүрэг болно. Ажлын байрны, гэр бүлийн хүрээний архидалтыг бууруулахад чиглэсэн нөлөөллийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, мөн архины байнгын хамааралтай иргэдийг гэр бүлийн гишүүд, нийгэмд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлж, цагдаагийн байгууллагын зохион байгуулалтаар албадан эмчилгээ, сэтгэлзүйн хөтөлбөрт хамруулж, урт хугацаанд архины хамаарлаас гаргах өргөн хүрээтэй үйл ажиллагаа зохион байгуулна.
8. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, нийт хүн амын дийлэнх хувийг эзэлж байгаа залуучууд эрүүл чийрэг, амьдралын зөв хэмнэлтэй амьдрах бололцоог бүрдүүлнэ.

#### Чиглэл 4: Амьдрахад таатай дүүрэг

Дүүргийн хэмжээнд нийгмийн халамж нь зорилтот бүлэгтээ хүрдэг, гэмт хэргийн гаралт багатай, худаг ус, ариун цэврийн байгууламжуудын хүрэлцээтэй дүүрэг болно.

1. Хүүхэд, эмэгтэйчүүдэд чиглэсэн гэр бүлийн хүчирхийллийг бүрэн таслан зогсоохын төлөө тууштай ажиллаж ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ хамгийн бага түвшинд хүрсэн дүүрэг болох зорилт дэвшүүлнэ.
2. Дүүргийг бүхэлд нь хамарсан камерын хяналтын тогтолцоог бий болгож, иргэдийн өмч хөрөнгийн бүрэн бүтэн аюулгүй байдлыг хангана.




3. Баянзүрх дүүргийн хэмжээнд тодорхой тооны иргэд төрөөс халамж дэмжлэг авч байна. Цаашдаа 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй 3000 орчим өрх, өрх толгойлсон эцэг болон эх 5000 орчим, хагас өнчин 2800 хүүхэд, бүтэн өнчин 366 хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй 8000 гаруй иргэдэд төрийн халамж дэмжлэгийг бодитойгоор хүргэж ХҮМҮҮНЛЭГИЙН ЗАГВАР ДҮҮРЭГ болно.
4. Хүн амын ундны усны хүртээмжийг дээшлүүлж, худгийн тоог нэмэгдүүлж, одоо байгаа худгуудыг ухаалаг худаг болгоно. Баталгаат ундны эх үүсвэргүй өрхүүдийг ундны баталгаатай эх үүсвэрээр хангана.
5. Гэр хорооллуудын дунд байрлаж буй халуун усны үйлчилгээний 65 цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн сайжруулж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар уг тоог нэмэгдүүлнэ.
6. Газрын тухай хуульд заасан өрх бүр газар өмчилж, эзэмших бололцоог хуулийн хүрээнд хангаж ажиллана.

### Чиглэл 5: Дэд бүтцийн таатай зохион байгуулалттай дүүрэг

Улаанбаатар хотын хүн амын нягтаршлын дийлэнх хэсэг нь ногдож байгаа байгаа манай дүүргийн тулгамдсан асуудал нь амьдрах орчин болоод байна. Хотхонууд нь зай талбай нийгмийн байгууламжгүй, шавааралдсан олон байшин дунд хүүхэд, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломжгүй, гэр хорооллын гудамж, зам, гүүр, гэрэлтүүлэг ногоон байгууламж маш хангалтгүй байгааг ирэх жилүүдэд бүхэлд нь өөрчлөн нийт иргэдийн амьдрах орчныг сайжруулан, тав тухтай, аюулгүй орчинд амьдрах боломжийг хангана.

1. Дүүргийн барилгажсан хэсгүүдэд хууль тогтоомж стандартуудыг сайтар мөрдүүлж, шинээр улс нийслэлээс газар олгох, барилга байгууламж барих ажиллагаанд одоо байгаа орон сууцны иргэдийн эрхийг хохироохгүй байх шаардлага тавьж, дүүргийн нийт хотхонуудын мэдлийн нийтийн эзэмшлийн гудамж талбайнуудыг бүхэлд хамгаалах, бусад этгээдүүд халдах боломжийг бүрэн хязгаарлаж, газрыг дүүргийн захиргаа, газрын албаны зүгээс баталгаажуулна.
2. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг захиргааны санаачлагаар бус иргэдийн санал дээр тулгуурлан иргэний эрх ашигт нийцүүлэн, тэдний хяналтын доор хуулийн хүрээнд зохион байгуулна. Газар эзэмшигчдийн зөрчигдсөн эрхийг хамгаалах сэргээх арга хэмжээ авна.
3. Хотхон орон сууцнуудын дундах автозогсоолыг өргөтгөн нэмэгдүүлэх, дүүргийн хэмжээнд дулаан гаражийн /нэг болон олон давхар/ тоог хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар нэмэгдүүлнэ.
4. Дүүргийн хэмжээнд өнөөдрийн байдлаар гэрэлтүүлэгтэй гудамж 4139,4 км байгааг нэмэгдүүлж, гэр хорооллын дундах гэрэлтүүлгийг сайжруулна.




5. Сансрын уулзвараас Дамбадаржаа хүртэлх зам болон Дарь-эх, Шар хад зэрэг гэр хорооллын дундах замыг стандартын дагуу өргөтгөж, явган хүн, дугуйн зам, үерийн усны зайлуулалт, гэрэлтүүлгийн хэсгийг хамтад нь тохижуулна.
6. Гэр хорооллын гуу жалга, хүүхдийн сургуулийн ойролцоох газар, төмөр замын ойролцоох хотхонуудад явган хүний гүүр, нүхэн гарцуудыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.
7. Дүүргийн хэмжээний үер усны байгууламжуудын өнөөгийн бүтцийг зураглаж, үер усны гамшгаас бүрэн сэргийлэх нэгдсэн төлөвлөлт бүхий үер усны байгууламжийн тогтолцоог бүрдүүлж, нэн шаардлагатай газруудын үеийн далан, ус зайлуулах системийг шинэчлэн сайжруулна.

### **Чиглэл 6: Чөлөөт цагаа өнгөрүүлэхэд таатай дүүрэг**

Баянзүрх дүүрэг бол залуучуудын дүүрэг. Тиймээс залуучууд нь хөгжиж, ажиллахаас гадна чөлөөт цагаа буруу дадал зуршлаар бус байгальд ойр, амьдарлын зөв дадал зуршилтайгаар өнгөрүүлэх боломжийг бий болгох юм. Нийт иргэд ажлын бус цагаа таатайгаар өнгөрүүлэх нийгмийн байгууламжуудыг хүрэлцээтэй хэмжээгээр байгуулж, чөлөөт цагаа хамтдаа өнгөрүүлэх нэгдсэн үйл ажиллагаануудыг тогтмол зохион байгуулна.

1. Сүхбаатар жанжны нэрэмжит хүүхэд залуучуудын соёл амралтын цогцолбор байгуулна.
2. Баянзүрх цэцэрлэгт хүрээлэн, соёл спортын цогцолбор, залуучууд жилийн дөрвөн улиралд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломжийг хангах сагсан бөмбөг, хөлбөмбөг, пэйнбол, талбайн теннис, хоккэй зэрэг спортын талбайнуудыг хувийн хэвшлийн болон төсвийн хөрөнгө оруулалтаар байгуулна.
3. Дүүргийн хэмжээнд хүүхдийн тоглоомын талбайг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.
4. Дүүргийн хэмжээнд цэцэрлэгт хүрээлэн 5 байгааг нэмэгдүүлж Туул голын сав дагуу, Улиастайгаас Гачуурт хүртэлх туул голын ундны эх үүсвэрийн хэсэгт, Шар хадны эцсээс хойшоо байх Шар хоолой, Гачууртын эцсээс хойших хөндий, Богд уул, Дарь-Эх цогцолбор гэсэн 6 байрлалд тус тусын онцлогт тохирсон байдлаар холбогдох төрийн байгууллагуудтай хамтран цэцэрлэгт болон соёл амралтын хүрээлэн байгуулна. Ингэснээр дүүрэг нь Улаанбаатар хотын хот орчмын аялал жуулчлалын төв болно.
5. "ХОТХОНЫ СОЁЛ" хөтөлбөрийг хэрэгжүүлж, хотхон нь тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэх, хамтын асуудлаа нэгдэн шийдвэрлэх өргөн хүрээний боломжуудаар хангаж ажиллана.
6. Бүх ногоон байгууламж, чөлөөт цагаа өнгөрүүлэх талбайнуудыг дүүргийн хэмжээнд бүхэлд нь хамгаалалтад авч, бүртгэлжүүлнэ.



## Чиглэл 7: Хоггүй, ногоон дүүрэг


Дэлхий нийтэд түгээмэл болоод буй байгальд ээлтэй амьдрах, хог хаягдал бага гаргах, гаргасан хогоо ангилан ялгах дадлыг иргэддээ төлөвшүүлэх, ангилсан хог хаягдлыг дахин боловсруулах, хогийг баялаг болгох иж бүрэн тогтолцоог бий болгоно. Дүүргийн хэмжээнд одоо байгаа ногоон байгууламжуудаа бүрэн хамгаалалтад авч улмаар ногоон байгууламжуудын хэмжээг иргэд, хувийн хэвшил, төрийн хөрөнгө оруулалтаар их хэмжээгээр нэмэгдүүлэх, дүүргийн газар нутгаар урсаж буй голуудын хөндий дагасан ногоог байгууламжуудыг бий болгоно.

1. Өрх бүр, орон сууц бүр хог хаягдлыг ангилан ялгах дадалд суралцаж, иргэн бүрийн оролцоонд тулгуурлан хогийг дахин боловсруулах хувь хэмжээг нэмэгдүүлнэ.
2. Дүүргийн хог хаягдлыг тээвэрлэх тогтолцоог иж бүрэн шинэчилж, хог тээврийн 58 машин байгааг нэмэгдүүлж ажиллана.
3. Дүүргийн хэмжээнд хог устгалын 2 цэгийг өргөтгөн хүчин чадлыг нэмэгдүүлэх ба мөн Цагаан давааны хогийн цэг дээр шил хуванцар гялгар уут, цаасны хаягдлыг ангилж, боловсруулах үйлдвэр шинээр байгуулна.
4. Ургамлын гаралтай харшил үүсгэгч шарилж зэрлэг ургамлыг устгах ажиллагааг жилийн турш тогтмол гүйцэтгэнэ.
5. Хот орчмын ногооны талбай бүхий иргэдийг дэмжинэ.

## Чиглэл 8: Үйлчлүүлэхэд таатай дүүрэг

Төрийн үйлчилгээг сайжруулж, хүнд сурталгүй, иргэний эрхийг дээдэлсэн технологийн хөгжилд суурилсан, хүртээмжтэй болгох ба дүүргийн бүх төрийн байгууллагуудыг захиргааны бүтцээс иргэний үйлчилгээний бүтцэд бүрэн шилжүүлнэ.


1. Монгол улсын нийт иргэдийн 10.6 хувь нь амьдарч байгаа дүүргийн хувьд улсын төсвийн 11-ээс дээш хувь, нийслэлийн иргэдийн 25 хувь нь амьдарч байгаа дүүргийн хувьд нийслэлийн төсвийн 25-аас дээш хувь нь тус дүүрэгт зарцуулагддаг байх, дүүргийн иргэдэд үйлчилгээ үзүүлэх төрийн албан хаагчдын тоог их хэмжээгээр нэмэгдүүлэх шаардлагыг Засгийн газар, төрийн бодлогын хэмжээнд тавьж хөрөнгө оруулалт, төсвийн хэмжээг нэмэгдүүлэх боломжуудыг ашиглана.
2. Төрийн албан хаагчид иргэдэд бүрэн хүрч ажиллах тогтолцоог бүрдүүлж, ХОТХОН БҮРИЙГ ХАРИУЦАН АЖИЛЛАХ мөн гэр хорооллын 5 гудамж тус бүрийг хариуцан иргэдийн асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий төрийн албан хаагчдыг томилж, төр нь иргэддээ түрүүлж хүрэх, үйлчилгээгээ бодитой болгох санаачлагыг хэрэгжүүлнэ.



3. Өнгөрсөн 8 жилийн хугацаанд шийдвэрлээгүй удаашралтай байгаа, хэн хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй өргөдөл гомдлуудыг дүүргийн удирдлагыг авснаас хойш 80 хоногийн дотор бүрэн шийдвэрлэж нэг бүрчлэн мэдээлнэ.
4. Иргэдээс утсаар, биеэр, цахимаар, аппликейшнээр, нэг цэгийн үйлчилгээгээр, цахим сүлжээгээр зэрэг боломжит бүх эх үүсвэрээс авсан санал, хүсэлт, мэдээлэл, гомдлыг хуульзүйн хувьд хүчинтэйд үзэж, шийдвэрлэнэ. Төрийн байгууллагад гаргасан эдгээр гомдлыг 30 ба түүнээс олон хоногоор шийдвэрлэдэг хуучин хүнд сурталт тогтолцоог халж, өргөдөл гомдлыг 1-7 хоногийн дотор шийдвэрлэдэг түргэн шуурхай тогтолцоог нэвтрүүлнэ.
5. Төр өөртөө байгаа төрөл бүрийн мэдээллийг иргэнээс дахин шаардаж, бичиг цаас бүрдүүлбэр нэхэж, иргэдийг чирэгдүүлдэг тогтолцоог бүрэн халж ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ГЭРЭЭСЭЭ авах тогтолцоог бүрдүүлнэ.
6. Дүүргийн төсөв, түүний бүх зарцуулалт, дүүргийн газар зохион байгуулалт, хөрөнгийн хэмжээ, байрлал, дүүргийн бүх шатны байгууллагаас гаргаж буй бүх төрлийн шийдвэрүүдийг нийтэд цахим хаягаар дамжуулан ил тод мэдээлнэ. Дүүргийн сонгуульд ялалт байгуулж бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсэн өдрөөс энэхүү зорилтыг шууд хэрэгжүүлнэ.
7. Дүүргийн хэмжээнд ажиллаж буй нийт төрийн байгууллагуудын ажилтан сонгон шалгаруулалтыг бүхэлд нь шинэчилж нээлттэй сонгон шалгаруулалтын зарчмыг нэвтрүүлж, дүүргийн үндсэн иргэдийг тэргүүн ээлжинд ажлаар хангахад анхаарч ажиллана.
8. Эрх нь зөрчигдсөн иргэдэд хууль зүйн болон бусад туслалцааг үзүүлдэг ИРГЭДЭД ТУСЛАХ ТӨВ-ийг ажиллуулж иргэнийхээ эрхийг зөрчдөг бус хамгаалдаг байна
9. Жил бүр дүүрэг өөрийн хүсэлтээр Төрийн аудитын байгууллага, Авлигатай тэмцэх газруудаас хяналт шалгалт хүлээн авч үр дүнг нь нийтэд мэдээлэх замаар ил тод байдлаа өөрсдөө бүрдүүлнэ.

Мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг дараах байдлаар бүрдүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

1. **Улсын төсвийн хөрөнгө оруулалт, санхүүжилт** – Тухайн жилийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын Баянзүрх дүүрэгт хуваарилах санхүүжилтээр мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг санхүүжүүлнэ.
2. **Нийслэлийн төсвөөс дүүрэгт ногдох хөрөнгө оруулалт, санхүүжилт** - Тухайн жилийн улсын нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын Баянзүрх дүүрэгт хуваарилах санхүүжилтээр мөрийн хөтөлбөрийг санхүүжүүлнэ.
3. **Баянзүрх дүүргийн төсөв** – Баянзүрх дүүргийн батлагдсан төсвийн орлогоор мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг санхүүжүүлнэ.



4. **Олон улсын байгууллагын хөрөнгө оруулалт, дэмжлэг** – Ирэх 4 жилийн хугацаанд харилцаа хамтын ажиллагааг сайжруулж, Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа болон бусад олон улсын байгууллагаас хөрөнгө оруулалт дэмжлэгийг татан төвлөрүүлж ажиллана.
5. **Хамтын ажиллагаатай гадаад улсуудын хот, дүүргүүдийн хөрөнгө оруулалт, буцалтгүй тусламж** – Дэлхийн өндөр хөгжилтэй болон хөгжиж буй орнуудын хот, томоохон дүүргүүдтэй хамтын ажиллагаа өрнүүлж, тэдгээрийн зүгээс хөрөнгө оруулалт, дэмжлэгийг татан төвлөрүүлнэ.
6. **Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт** – Дүүргийн хэмжээнд одоо ажиллаж байгаа болон ирэх жилүүдэд бий болох хуулийн этгээдүүдтэй хамтран ажиллаж, тэдгээрийн нийгмийн хариуцлагын болон бизнесийн төслүүдийг дүүргийн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлд зориулан ажиллана.

#### **БОЛОВСРУУЛСАН:**

**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН НАМ**





**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: [ub@audit.gov.mn](mailto:ub@audit.gov.mn), Вэбсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)

2020.07.09 № 1230

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Налайх дүүргийн Монгол ардын намаас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа-2050”, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Налайх дүүргийн Монгол ардын намын дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-


2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Налайх дүүргийн Монгол ардын намын мөрийн хөтөлбөр 1.4 хуудас/-ийг хавсаргав.

Хувийг. Налайх дүүргийн сонгуулийн хороонд

Хавсралт: 4 хүүдэстэй

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НОМИНБААТАР



Нийслэлийн Налайх дүүргийн Монгол Ардын Намын хорооны 2020 оны 6 дугаар сарын 21 -ний өдрийн 02 дугаар хуралдааны 2 дугаар тогтоолын хавсралт



**НАЛАЙХ ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН НАМААС АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**Уриа: Хүн бүр хөгжлийн төлөө “ХҮЧЭЭ НЭГТГЭЭ”**

**Нэг. ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭЭДЛЭГЧ НАЛАЙХ**

**1.1 Эрүүл иргэн**

1.1.1 300 ортой орчин үеийн стандартад нийцсэн тоног төхөөрөмж бүхий эрүүл мэндийн нэгдсэн шинэ төв байгуулна.

1.1.2 Өрхийн эрүүл мэндийн төвийн үйлчилгээнд чанар хүртээмж, дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.

1.1.3 Өсвөр үе, цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг дэмжин, дүүргийн Эрүүл мэндийн төвд эрэгтэйчүүдийг эмчлэн, эрүүлжүүлнэ.

1.1.4 Шүд, амны хөндийн эрүүл ахуйн хөтөлбөр хэрэгжүүлж, эм, эмийн сангийн хүртээмж, чанарыг нэмэгдүүлнэ.

**1.2 Чанартай боловсрол**

1.2.1 Улс, Нийслэл, Олон улсын байгууллагын санхүүжилт хандив тусламжаар СӨБ-ын хүртээмж, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлж, хүүхэд харах үйлчилгээг өргөжүүлнэ.

1.2.2 Ерөнхий боловсролын сургуулийг шинээр барьж байгуулах, өргөтгөх замаар хүчин чадлыг нэмэгдүүлж, бүлэг дүүргэлтийг стандартад хүргэнэ.

1.2.3 Насан туршийн боловсролын төв, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хосолмол сургууль, бүх шатны боловсролд тэгш хамруулах, онлайн болон зайны сургалтыг нэмэгдүүлэн, төгсөгчдийг дараагийн шатны сургалт дадлага, ажлын байранд сургах үе шаттай тогтолцоог бий болгоно.

1.2.4 Дүүргийн онцлогт тохируулан багшлах боловсон хүчин, хүүхдийн хөгжил, соёлч эрүүл зөв дадал, эерэг хандлагатай иргэн болгож төлөвшүүлэх “Налайхын Боловсрол 2020” хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

**1.3 Өв соёл, урлаг**

1.3.1 Соёлын ордны шинэ барилгыг ашиглалтанд оруулж, техник тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж, орчин үеийн стандарт бүхий кино театрттай болж, үндэстэн ястны өв соёлыг хөгжүүлнэ.

1.3.2 Их уурхайн 100 жилийн ойд зориулсан дурсгалт газар, аялал жуулчлал ногоон байгууламж бүхий амралт чөлөөт цаг өнгөрүүлэх төв, музей байгуулах ажлыг эхлүүлнэ.

1.3.3 Иргэдийн соёлын хандлагыг төлөвшүүлэх, “Соёлтой тархи” хөдөлгөөн өрнүүлж, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлнэ

**1.4 Спорт, бүх нийтийн үйлс**

1.4.1 Бүх насны иргэдийн биеийн тамирыг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, стандартад нийцсэн спорт заалыг нэмэгдүүлнэ.



1.4.2 Иргэд, олон нийтийг биеийн тамир, спортоор хичээллэх орчныг бүрдүүлж, олон улсын болон улсын чанартай тэмцээнд оролцох боломжийг бүрдүүлнэ.

1.4.3 Цэцэрлэгт хүрээлэн, иж бүрэн спорт тоглоомын талбайн тоог нэмэгдүүлнэ.

## **1.5 Гэр бүл, залуучуудын хөгжил**

1.5.1 Хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх соёл амралтын төвтэй болно.

1.5.2 Хүүхэд, гэр бүлийн эсрэг нийгмийн хүчирхийлэлтэй тэмцэж, түүнээс урьдчилан сэргийлсэн хяналтын тогтолцоог бүрдүүлэн түр хамгаалах байрыг бий болгож, хороо бүрт гэр бүлийн зөвлөгөө өгөх танхимтай болно.

1.5.3 “Залуу малчин”, “Бид бүтээгч, үйлдвэрлэгч залуучууд” хөтөлбөр хэрэгжүүлж, нарийн мэргэжилтэй ажиллах хүчин, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

1.5.4 Аялал жуулчлал, бизнес, соёлын харилцааг хөгжүүлж, залуусын цахим болон төрөлжсөн үйлчилгээтэй оршин суух хотхон бий болгоно.

## **1.6 Хөдөлмөр, нийгмийн халамж, хамгаалал**

1.6.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэнд болон нийгмийн хамгааллыг дэмжих амьдралын чанарыг сайжруулах хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.6.2 Ахмад настны амралт, сувилалын төвийг байнгын ажиллагаатай болгож, чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.6.3 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, “Залуучуудын гарааны бизнесийг дэмжих төв ажиппуупна

1.6.4 Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих зорилгоор олон улсын үзэсгэлэн худалдаа бусад улс, хотуудтай холбох бодлого боловсруулж ажиллана.

## **Хоёр. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛӨӨР ТЭРГҮҮЛЭГЧ НАЛАЙХ**

### **2.1 Хөрөнгө оруулалтыг дэмжих**

2.1.1 Дулааны станцын өргөтгөл шинэчлэлийг хийж, Налайх дүүргийн дулаан хангамжийг бүрэн шийднэ.

2.1.2 Таван толгойн сайжруулсан түлшний үйлдвэрийг барьж, ашиглалтанд оруулна.

2.1.3 Эрчим хүчний нэмэлт шинэ дэд станцуудын бий болгож, дүүргийн иргэд, аж ахуйн нэгжийг эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбоно.

2.1.4 Хог ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэр байгуулж, дулаан болон цахилгааны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

2.1.5 Гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

2.1.6 Нутгийн удирдлагын ордны барилгын ажлыг эхлүүлнэ.

2.1.7 960 хүүхдийн суудалтай Голомт цогцолбор сургуулийг барьж, ашиглалтанд оруулах

### **2.2 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих**

2.2.1 “Хамтдаа хөгжинө, Налайхад үйлдвэрлэв” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.



2.2.2 Эрчимжсэн мал аж ахуй, хүнс хөдөө аж ахуйн чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх бодлого баримтлана.

2.2.3 Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах сонирхолтой иргэн, аж ахуйн нэгжүүдийн дэд бүтцийг шийдвэрлэхэд хамтран ажиллана.

2.2.4 Үйлчилгээний стандартын шаардлага хангасан ахуй үйлчилгээний нэгдсэн төвийг бий болгох ажлыг эхлүүлнэ.

### **2.3 Аялал жуулчлалыг дэмжих**

2.3.1 Аялал жуулчлалын маршрутыг нэмэгдүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллана.

2.3.2 Гадаад дотоодын жуулчдад үйлчилгээ үзүүлдэг амралт, аялал жуулчлалын баазууд, үндэсний зан заншил, соёл урлаг, шашин үйлийг түшиглэсэн үйлчилгээг дэмжин ажиллана.

### **2.4 Төр, хувийн хэвшлийн түншлэл**

2.4.1 Дүүрэгт хийгдэх бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэхэд анхаарч, томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг үргэлжлүүлнэ.

2.4.2 Налайх дүүргийг бие даасан, төсвөө өөрөө бүрдүүлдэг хот болгох эхлэлийг тавина.

2.4.3 Барилгын материал үйлдвэр технологийн парkyг хөгжүүлэх.

## **Гурав. ИРГЭНДЭЭ ЭЭЛТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

### **3.1 Иргэнд чиглэсэн цахим төрийн үйлчилгээ**

3.1.1 Цахим архивын сан үүсгэн, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай авдаг нөхцлийг бүрдүүлнэ.

3.1.2 Төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэх “Нэг цонхны үйлчилгээ”-г сэргээн эрчимжүүлж, “27-27 төв” болгон үйл ажиллагааг өргөтгөж, иргэдийн нэгдсэн мэдээллийн төв болгоно.

3.1.3 Иргэдийн аюулгүй байдлыг хангах ажлыг эрчимжүүлж, авто зам, гудамж, олон нийтийн зам талбайг бүрэн камержуулан, хяналтын цогц шийдлийг нэвтрүүлнэ.

3.1.4 Төрийн бодлого, хууль, журам боловсруулан, шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгөх, хяналт тавих боломжийг бүрдүүлнэ.


3.1.5 Төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж, хөгжүүлэх цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, ёс зүй, хандлагыг эрс шинэчилэн, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

## **Дөрөв. АМЬДРАХАД ЭЭЛТЭЙ ЭКО НАЛАЙХ**

### **4.1 Хариуцлагатай уул уурхай**

4.1.1 Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд болон уул уурхайн ашиглалтаас орхигдсон газарт нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, эко системийн тэнцвэрт байдлын хадгална.

4.1.2 Усны аюулгүй байдлын тухай хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган тоосго, төмөр, цементний үйлдвэрт гүний ус ашиглахыг хязгаарлаж, хэрэглэсэн усыг дахин ашиглах саарал ус нийлүүлэх ажлыг дэмжинэ.



4.1.3 “Эко Налайх” хөтөлбөрт тусгагдсан ус, агаар, хөрс орчны бохирдлыг бууруулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

4.1.4 Агаарын бохирдлыг бууруулах, амьдрах таатай орчин бүрдүүлэх зорилгоор ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин ажиллана. Дүүрэг хороололд бичил цэцэрлэг байгуулж, нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.

4.1.5 Явган явах дугуйгаар зорчих орон зайг нэмэгдүүлэх үүднээс “Гудамж” “Дугуйн зам” дэд хөтөлбөр хэрэгжүүлж, хотын төвтэй дугуй, явган замаар холбоно.

4.1.6 “Аюулгүй дүүрэг” төслийг хэрэгжүүлж, гэмт хэргийг гаралтыг бууруулна.

## **Тав. ИРЭЭДҮЙН ЖИШИГ ХОТ НАЛАЙХ**

### **5.1 “Нэг хот - Нэг стандарт”**

5.1.1 Гэр хороолол, орон сууц, нийтийн эзэмшлийн талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх.

5.1.2 “Ногоон хороо - Ногоон гудамж” хөдөлгөөн өрнүүлэх, гудамжнуудын өнгө үзэмжийг сайжруулж, хаягжилтыг нэг стандартад оруулах ажлыг эхлүүлнэ.

5.1.3 Усан хангамж, худаг ухаалаг худгийн тоог нэмэгдүүлэх.

5.1.4 Нэг цэгийн үйлчилгээний байрнуудыг стандартын хүрээнд тохижуулж, засварлаж, шинэчлэх.

### **5.2 Хотын хөгжил хорооноос**

5.2.1 Гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг эхлүүлж, шинэ суурьшлын бүсэд гэрэлтүүлгийн зураг төсөв хийнэ.

5.2.2 Гэр хорооллын дундах авто замын зураг төсөвтэй ажлын хөрөнгийг шийдвэрлүүлэх. /1,4,5,6,7,8-р хорооны/

5.2.3 Шинэ суурьшлын бүс, хүчдэлийн уналттай айл өрхийн асуудлыг шийдвэрлэх.

5.2.4 Гэр хороолол, орон сууцны айл өрхийг инженерийн шугам сүлжээнд холбох.

5.2.5 Хороонд хүүхдийн тоглоомын талбайг нэмэгдүүлж, засварлаж, шинэчлэн, хөл бөмбөгийн талбай шинээр байгуулна.

5.2.6 Дүүрэгт “Олон нийтийн хөгжлийн төв” байгуулах ажлыг эхлүүлнэ.

5.2.7 1 дүгээр хороонд бие даасан интернетийн байгууламж бий болгож, айл өрхийг холбоно.

ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 0 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.07.10 № 1752  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
СҮХБААТАР ДҮҮРГИЙН МОНГОЛ  
АРДЫН НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Сүхбаатар дүүргийн Монгол Ардын намын хорооноос ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хорогжлоход шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа-2050”, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Сүхбаатар дүүргийн Монгол Ардын намын хорооноос дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн

37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сүхбаатар дүүргийн Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /4/ хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сүхбаатар дүүргийн сонгуулийн хороонд

Хавсралт: 4.. хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР



**СҮХБААТАР ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНООС  
ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД  
ОГОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Монгол Ардын Намаас 2020 оны УИХ болон НИТХ-ын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрийн зорилтуудыг үндэслэл болгож

**“СҮХБААТАРЧУУД АА ХҮЧЭЭ НЭГТГЭЭ”** уриаг дэвшүүлж, дүүргийнхээ иргэдийн амьжиргааг сайжруулахын төлөө дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр Сүхбаатар Дүүргийн Монгол Ардын Намын байгууллагаас сонгуулийн мөрийн хөтөлбөрөө хүргүүлж байна.

1. **Хүний хөгжлийн дэмжигч дүүрэг**
2. **Ходолмор эрхлэгчдийг дэмжигч дүүрэг**
3. **Жишиг дүүрэг**
4. **Нээлттэй цахим дүүрэг**
5. **ЭКО дүүрэг** гэсэн 5 зорилтыг 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт тусгалаа. Энэхүү мөрийн хөтөлбөр 5 бүлэг, 69 заалттай.


**НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИГЧ ДҮҮРЭГ**

**1.1 Боловсролтой иргэн**

1. Орчин үеийн технологийн дэвшлийг ашиглан сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд Монгол ахуйтай танилцах нөхцлөөр хангана.
2. Төгсөх ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, үйл ажиллагааг зохион байгуулна.
3. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн гадна талбай, спорт заалыг хүүхдэд ээлтэй аюулгүй байдлаар тохижуулж орчин үеийн стандарт шаардлагад нийцүүлнэ.
4. Жил бүр дүүргийн ЕБС-ийн төгсөгчдөөс элсэлтийн ерөнхий шалгалтандаа 700-аас дээш оноо авч их дээд сургуульд элсэн орсон амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой зорилтод бүлгийн шилдэг сурагчдыг дэмжих бодлого барьж ажиллана.
5. Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг цэцэрлэгт бүрэн хамруулах асуудлыг шийдвэрлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
6. Дүүргийн нийтийн номын сан барьж сургууль, цэцэрлэг, эмнэлгийн дуусаагүй барилгуудыг ашиглалтад оруулж шаардлагатай хороодод шинээр байгуулах бодлогыг дэмжинэ.
7. Байгууллагын дэргэдэх цэцэрлэг байгуулах санаачлагыг дэмжиж, мэргэжлийн байгууллагуудын зөвлөн туслах баг ажиллуулна.
8. Олон улсын хот, дүүргүүдтэй Хамтын ажиллагааны гэрээ байгуулж төрийн албан хаагч, багш, эмч, сувилагчдын мэдлэг туршлагыг солилцуулах, чадавхийг нь дээшлүүлж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

**1.2 Эрүүл иргэн**

1. Дүүргийн нэгдсэн эмнэлгийг шинээр барьж, орчин үеийн шаардлагад нийцсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр ханган, оношилгоо, эмчилгээний хүчин чадлыг нь нэмэгдүүлэх, эмч, эмнэлгийн ажилтнуудын ажиллах орчинг сайжруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
2. Өрхийн эмнэлгийн статусыг тодорхой болгуулж, санхүүжилтыг оновчтой хэлбэрээр шийдвэрлэн, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
3. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон өсвөр насны хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, сайжруулах тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.
4. Иргэдийг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг хянах тогтолцоог боловсронгуй болгож, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
5. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, чийрэгжүүлэх, тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.
6. Дүүргийн иргэдийн бялдаржуулах клуб болон фитнес төвүүдээр үйлчлүүлэх нөхцлийг хөнгөвчлөх чиглэлээр Нийгмийн даатгалын ерөнхий газар болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран судалгаа хийж, шийдвэрлүүлэн хэрэгжүүлж ажиллана.





1. Агаарын чанарын бүсэд байгаа, айл өрх, ААН байгууллагуудыг сайжруулсан түлшээр бүрэн хангах, түлш нөөцлөх, түгээх, борлуулах цэгүүдийг өргөтгөн иргэдэд хүртээмжтэй сүлжээг бүрдүүлнэ.
2. Төвлөрсөн дулаанд холбогдох боломжгүй гэр хорооллын айл өрх, ААН байгууллагыг хийн болон төвлөрсөн дулаан хангамжид холбох, цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлнэ.
3. Гэр хорооллын гудамж, зам талбай, гэмт хэрэг зөрчил ихээр үйлдэгдэж болзошгүй газрын гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлнэ.
4. Орон сууцны болон гэр хороолол, аж ахуй нэгжийн хаягжилтыг нэгдсэн стандартанд оруулах бодлого хэрэгжүүлнэ.
5. Хуучны угсармал байрнуудын дулаан алдалтыг багасгах, "Дулаан байр" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
6. Хороолол, гудамж хаасан орц, гарцыг нээж иргэдийн аюулгүй, чөлөөтэй зорчих орчныг бүрдүүлнэ.

### 3.2 Иргэдийн амьдралд таатай тохилог орчин бүрдүүлнэ

- 1 Дүүргийн хэмжээнд "Жишиг хороо" гэр хороололд "Жишиг гудамж", орон сууцны хороололд "Жишиг орц" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2 Ахмад настан, залуус, хүүхдэд зориулсан чөлөөт цагаа өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэн бий болгох ажлыг эхлүүлнэ.
- 3 Сэлбэ голын эрэг дагуу амралт чөлөөт цаг өнгөрөөх байгууламж барихыг дэмжинэ.
- 4 Дүүргийн "Хандгайт" ахмадын амралтын үйл ажиллагааг жигдрүүлж, ахмадуудыг өргөн хүрээтэй амрах нөхцлийг бүрдүүлнэ.
- 5 1970-аад оноос өмнө баригдсан угсармал орон сууцны дулаан эрчим хүчний алдагдлыг бууруулах зорилгоор орон сууцны дулаалга хийж, нийтийн эзэмшлийн зам талбайн ус зайлуулах шугам хоолойн ашиглалтыг сайжруулах зорилтыг дэмжинэ
- 6 Орон сууцны цахилгаан шат, дээврийг шинэчлэн засварлах, гадна дулаалга, фасадын ажлыг 1-10 дугаар хороодуудад үе шаттай зохион байгуулна.
- 7 Орон сууцны хороолол дундах автомашины зогсоолыг шинэчлэн сайжруулж, орчин үеийн шийдэл бүхий ил болон олон давхар авто зогсоолыг нэмэгдүүлнэ.

### 3.3 Иргэнд ээлтэй, хүртээмжтэй дэд бүтцийг байгуулна

- 1 Хямралын улмаас зогссон үйлдвэрлэл, үйлчилгээг сэргээж, ажлын байр бий болгоход хувийн хэвшилтэй нягт хамтран ажиллана.
- 2 Дүүргийн гадаад харилцааг өргөжүүлж дэд бүтэц, ногоон байгууламж, хот төлөвлөлтийг сайжруулан, хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.
- 3 Хороодын нутаг дэвсгэрт үерийн усны далан барьж, бороо болон хөрсний ус зайлуулах инженерийн шугам сүлжээний ажлыг шинээр байгуулах ажлыг дэмжинэ.
- 4 Гэр хорооллын усан хангамжийг сайжруулна.
- 5 Төвийн хороодын хороолол дундах авто замыг иж бүрэн шинэчилж, гэр хорооллын гудамж талбайн дундах авто замыг сайжруулна.
- 6 Зуслангийн газар өмчлөлийн бодлогыг эрчимжүүлж, иргэдээ газар өмчлөх, эзэмших эрхээ эдлэх боломжийг өргөжүүлнэ.
- 7 Автобусны буудлуудын байршлыг зорчигчийн хэрэгцээнд тулгуурлан зохистой байршилд тохижуулна.

### ДӨРӨВ. ИЛ ТОД ЦАХИМ ДҮҮРЭГ

1. Төрийн албан хаагчдын ур чадвар, хариуцлагыг дээшлүүлж "Иргэн төвтэй үйлчилгээ" хөтөлбөрийг хэрэгжүүлж иргэдийн өргөдөл гомдол хүсэлтийг шуурхай шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлнэ.
2. Нутгийн удирдлагын болон захиргааны байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлж, уялдаа холбоог сайжруулна.
3. Хороо хөгжүүлэх сангийн хөрөнгийг ил тод болгож, иргэдэд нээлттэй, хүртээмжтэй болгоно.





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.07.09 № 1241

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН  
ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Сонгинохайрхан дүүргийн Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Сонгинохайрхан дүүргийн Монгол Ардын намын хорооны Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл,


сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сонгинохайрхан дүүргийн Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сонгинохайрхан дүүргийн сонгуулийн хороонд

Хавсралт: ... хуудастай


ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР






**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**  
*Сонгинохайрхан дүүргийн Монгол Ардын Нам*



### ЗОРИЛГО

ХҮН БҮРИЙГ ТЭГШ БОЛОВСРОЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧАНАРТАЙ, ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ХАНГАЖ, АМЬДРАЛЫН АЯ ТУХТАЙ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ САЙТАЙ ХАЯГДАЛ, БОХИРДОЛ БАГАТАЙ АЮУЛГҮЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛСЭН, БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХЭРЭГЛЭЭНИЙ СОЁЛТОЙ ХӨГЖСӨН ДҮҮРЭГ БОЛНО.



## ЗОРИЛТ 1. ЯДУУРЛЫГ БУУРУУЛЖ, ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ИРГЭДИЙГ ТОГТВОРТОЙ АМЬЖИРГААНД ХҮРГЭНЭ

*Нийгмийн халамжийг зөвхөн зорилтот бүлэгт олгож, хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай хүний ухамсар, зан төлөв, амьдралд итгэх итгэл үнэмшлийг өөрчилж, хөдөлмөрт бэлтгэх замаар ядуурлаас гаргана.*

Сонгинохайрхан дүүргийн хүн амын тоо сүүлийн 20 жилд 2 дахин өссөн.

Хөдөө орон нутгаас шилжин ирж суурьшигчдын асуудал дүүргийн хувьд тулгамдсан асуудал болж байна.

Шилжин ирэгсэд нь дэд бүтэц хөгжөөгүй, зөвшөөрөлгүй газарт суурьших нь тэдний эрүүл мэнд, аюулгүй байдлыг улам эмзэг болгож байна.



Сонгинохайрхан дүүргийн нийт өрхийн 26.2, хүн амын 46 хувь ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй байна.

Зорилт 1-ийг хангахын тулд доорх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:


1.1. Нийгмийн халамжийг зөвхөн зорилтот бүлэгт олгож хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай хүний ухамсар зан төлөв амьдралд итгэх итгэл үнэмшлийг өөрчилж хөдөлмөрт бэлтгэх замаар ядуурлаас гаргана.

1.2. Нийгмийн халамжийн үйлчилгээг ядуурлыг бууруулах зорилттой уялдуулж, нийгмийн халамж зайлшгүй шаардлагатай бүлэгт чиглэсэн арга хэмжээг зохион байгуулна

1.3. Өрх толгойлсон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд ахмад настан, хагас бүтэн өнчин хүүхдүүдэд чиглэсэн амьжиргааг дэмжсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ая тухтай амьдрах, хөгжих боломжийг бүрдүүлж ээлтэй орчинг бий болгоно.

1.5. Зорилтот бүлгийн өрхийн гишүүдэд гэр бүлийн боловсрол олгох, зан үйл хандлагыг өөрчлөх сургалтыг олон улсын болон мэргэжлийн байгууллага, иргэдийн оролцоонд түшиглэн зохион байгуулж хөдөлмөр эрхлэхэд бэлтгэнэ.



1.6. Ахмад настны хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Ахмадад ээлтэй дүүрэг” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.7. Ахмадын өргөөг байгуулж үйл ажиллагааг дэмжинэ.

## **ЗОРИЛТ 2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛНА**

***Эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хүчин чадал, тоног төхөөрөмжийг сайжруулж, хүн амын дундах халдварт ба халдварт бус өвчлөлийг бууруулан эх, хүүхдийн эндэгдлийг багасгана. Иргэдэд эрүүл зөв хооллох, стрессээ удирдах, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх эрүүл мэндийн боловсрол олгоно.***

Зорилт 2-ыг хангахын тулд доорх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.1. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж байгаа Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааг дэмжих эмч, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч, хувьсах зардлыг төрөөс бүрэн хариуцдаг болгоно.

2.2. Жишиг эмнэлгийг ашиглалтанд бүрэн оруулж, төрөх болон мэс заслын тасгийг нээн ажиллуулна.

2.3. Хавдар судлалын эмнэлэг байгуулна.

2.4. Өрхийн эрүүл мэндийн жишиг төвийг байгуулах ажлыг олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлнэ

2.5. Эрүүл мэндийн 2 дугаар амбулаторийг шинээр барьж ашиглалтанд оруулна. /Арван буудал/

2.6. Эрүүл мэндийн 2 дугаар шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагуудыг нарийн мэргэжлийн эмч, чадварлаг боловсон хүчнээр хангах, сургах, дадлагажуулах ажлыг үе шаттай зохион байгуулж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.


2.7. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулна.

2.8. Эх, нярайд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, эндэгдэл, нас баралтыг бууруулна.

2.9. Хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт бус өвчний /хавдар, чихрийн шижин, артерийн гипертенз/ тохиолдлыг бууруулах ажлыг зохион байгуулна.

2.10. “Эрүүл залуус-Эрүүл гэр бүл” хөтөлбөрийг хэрэгжүүлж, өсвөр үе, залуу гэр бүл, цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ.

2.11. Хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт өвчин, түүний дотор БЗДХӨ, сүрьеэгийн өвчлөлийг өмнөх жилүүдийнхээс бууруулна.



**ЗОРИЛТ 3. ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ  
ХҮҮХЭД БҮРТ ОЛГОНО**

**Хүүхэд бүрт хүртээмжтэй, чанартай боловсролыг олгож, сурч хүмүүжих эрүүл аюулгүй, эко орчин бүрдүүлэн, иргэдийн дунд насан туршийн боловсролыг олгоно.**

Зорилт 3-ыг хангахын тулд доорх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилгыг шинээр барьж байгуулах, өргөтгөх замаар хүчин чадлыг нэмэгдүүлж, анги дүүргэлтийн стандартыг мөрдүүлж, 1-2 ээлж рүү бүрэн шилжүүлнэ.

3.2. Бүх шатны боловсролын байгууллагуудын багшийн мэдлэг, мэргэшил, ур чадварыг нэмэгдүүлэх, багшийн хөгжлийг дэмжих, сургалтын чанарыг дээшлүүлэх, сурагчдын элсэлтийн ерөнхий шалгалтын оноог ахиулах, мэргэжил сонголтыг оновчтой болгох чиглэлээр “Боловсролыг дэмжих” төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.3. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гадна болон сургалтын орчин, тоног төхөөрөмжийг шинэчлэх, сайжруулах, сургуулиудад анги танхим, сургалтын төрөлжсөн кабинетуудыг иж бүрэн тохижуулна.

3.4. Сонгон, секц, дугуйланг тогтмол хичээллүүлэн хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлж сурлага, урлаг, спортын тэргүүний багш, сурагч, оюутныг шалгаруулж, гадаад оронд туршлага судлуулна.

3.5. Кембрижийн Олон улсын сургалтын хөтөлбөртэй 2-оос доошгүй ерөнхий боловсролын сургуулийг бий болгоно.

3.6. Шаардлагатай сургуулиудыг хүүхдийн автобустай болгох, дүүргийн хэмжээнд “Сурагч тээвэр” үйлчилгээг нэвтрүүлж ажиллана.

3.7. Сургууль, цэцэрлэгийн хүүхдийг эрүүл, шим тэжээллэг хоол хүнсээр хангаж, хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдалд хяналт тавьж, сургуулиудад “Үдийн хоол” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.


3.8. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сурч хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлэх, сургууль, цэцэрлэгийн багш нарыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй, сургалт мэдээлэл, гарын авлагаар хангана.

3.9. Тусгай хэрэгцээт хүүхдүүдэд зориулсан цэцэрлэг, сургууль байгуулна.

3.10. Албан бус насан туршийн боловсролын төвийг сургалтын байртай болгоно.

3.11. Боловсролын байгууллагын багш, эмч болон албан хаагчдад зориулсан түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.12. Сувилахуйн ухааны мэргэжлийн сургууль байгуулна.



#### **ЗОРИЛТ 4. ЗОХИСТОЙ АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛНЭ**

*Байгальд ээлтэй технологи бүхий үйлдвэрлэл нэмэгдэж, шинээр ажлын байр бий болгоно. Хөнгөн үйлдвэрлэлийн үйлдвэр технологийн паркттай болж, түүхий эдийн бирж, авто худалдааны төв, жижиглэнгийн болон бөөний худалдааны төвүүд байгуулагдана. Малчин өрхийн эрчимжсэн мал аж ахуйг дэмжинэ.*

Зорилт 4-ийг хангахын тулд доорх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1. Иргэдэд хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, тодорхой ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээлэл, ажил мэргэжлээ сонгох болон хөдөлмөр эрхлэлтийн дэмжих арга хэмжээнд хамрагдах нөхцлийн талаар ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэдээлэл зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлэх ажлыг зохион байгуулна. /Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр хэрэгжинэ/

4.2. Ажил идэвхитэй хайж буй иргэнийг сонирхол ур чадвар, мэргэжлийн дагуу ажлын байранд зуучлахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.3. Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулна.

4.4. Ахмад мэргэжилтнүүдийн хүсэлтэд үндэслэн ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж, тэдний мэдлэг, ажлын туршлагыг өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, өсвөр хойч, залуу үеийнхэнд хөдөлмөрийн дадал олгоно.

4.5. Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлвэрлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж тоог нэмэгдүүлнэ.

4.6. Түр ажлын байранд зуучилдаг төвийг байгуулж, иргэдийг ажилд зуучлах шинэ үйлчилгээг нэвтрүүлнэ.


4.7. Иргэдийг байнгын ажлын байраар хангах зорилгоор тэдний мэргэжил, ур чадварыг дээшлүүлж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, нийгмийн хамгааллыг үе шаттайгаар сайжруулна.

4.8. Орон нутгийн иргэдийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээ, мэдээллээр хангах боломжийг бүрдүүлж, цахим техник технологийг хөгжүүлэн, цаг алдалгүй мэдээллийг авах боломжийг бүрдүүлэх

4.9. Цагийн хөдөлмөр эрхлэлтийг тооцох аргачлалыг бий болгоно

#### **ЗОРИЛТ 5. ХОТЫН СОЁЛТОЙ ИРГЭДИЙГ ТӨЛӨВШҮҮЛНЭ**

*Иргэдийн соёл, урлагийн талаарх мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэн төлөвшүүлэх ажлыг хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулж, түүх, соёлын*



**дурсгалыг хадгалж хамгаалах, биет болон биет бус өв тээгчдийг нээн илрүүлж, хөгжүүлэх, сурталчлах ажлыг эрчимжүүлнэ.**

Зорилт 5-ыг хангахын тулд доорх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.1. Хүүхэд залуучуудын театртэй болно.

5.3. Эрүүл ахуй, гоо зүй, техникийн болон үйлчилгээний хэрэгцээ, чанарын шаардлагыг хангасан соёлын ордны барилгыг ашиглалтад оруулж, мэргэжлийн ажилтнаар бүрэн ханган, тэднийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ

5.4. Иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж хотын соёлтой иргэнийг төлөвшүүлнэ.

5.5. Номын сангийн фондыг баяжуулан, орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангаж, мэргэжлийн боловсон хүчний нөөцийг бүрдүүлнэ.

5.6. Гэрлэх ёслолын ордныг ашиглалтанд оруулна.

5.7. Ахмадын сувилал байгуулна /Бумбатын рашаан/

#### **ЗОРИЛТ 6. ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ ОРЧИН БҮРДҮҮЛНЭ**

**Залуучуудын сурч хөгжих боломжийг нэмэгдүүлж, зөвлөгөө мэдээлэл авах, ирээдүйгээ тодорхойлж, амьдралын чанараа дээшлүүлэхэд туслах үйлчилгээ үзүүлэн ажиллана.**

Зорилт 6-г хангахын тулд доорх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

6.1. Иргэдийн хөгжлийг дэмжих төвүүдийг бүс бүрт барьж ашиглалтад оруулан үйл ажиллагааг өргөжүүлнэ


6.2. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, иргэдийг хамгаалах байртай болгож хариу үйлчилгээний чанарыг сайжруулж, эрсдэлийг бууруулна.

6.3. Залуучуудын хөгжлийн жишиг төв байгуулна.

#### **ЗОРИЛТ 7. ГЭР ХОРООЛЛЫН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЖ, АМЬДРАХ ОРЧНЫГ САЙЖРУУЛНА**

**Гэр хорооллын өрхийг цахилгаан, эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбож, дулааныг төвлөрсөн болон хэсэгчилсэн байдлаар шийднэ. Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлнэ. Дүүргийн авто замуудыг сайжруулж, нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлнэ. Амины ногоон орон сууц төслийг хэрэгжүүлж гэр хорооллыг байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй дэвшилтэт технологи шингэсэн хувийн орон сууц, нам давхрын орон сууц болгон хөгжүүлнэ.**

Зорилт 7-г хангахын тулд доорх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:



7.1. Гэр хорооллын өрхийг цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрт бүрэн холбож, дулаан хангамжийг төвлөрсөн болон хэсэгчилсэн байдлаар шийднэ.

7.2. “Гэр хорооллыг орон сууцжуулах” хөтөлбөр болон “Амины ногоон орон сууц” төслийг хэрэгжүүлж, гэр хорооллыг байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, иргэдийн орлогод нийцсэн орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ.

7.3. Баянхошуу дэд төвийн бүтээн байгуулалтын ажлыг дуусгаж Толгойт дэд төвийг байгуулж орон сууцжуулах ажлыг эхлүүлнэ.

7.4. Гэр хорооллын төвийн бүсэд газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлж, өндөр давхрын орон сууцны хороолол, үйлчилгээний барилга байгууламж барина. “Газраа байраар сольё” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

7.5. Агаарын бохирдол ихтэй дундын бүсийн гэр хорооллын өрхүүдийг холбох хэсэгчилсэн дэд бүтцийн төвүүдийг барьж, нам давхрын орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлнэ.

7.6. Гэр хорооллын захын бүсэд байгаль орчинд ээлтэй, шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлж, бие даасан инженерийн дэд бүтцэд холбон, амины орон сууцны хорооллыг хөгжүүлж, үүнд иргэдийн оролцоог хангана.

7.7. “Орлогод нийцсэн орон сууц”, “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

7.8. Ашиглалтын шаардлага хангахгүй хуучирсан орон сууцнуудыг дахин төлөвлөж, барилгажуулах ажлыг үргэлжүүлнэ.

7.9. Эрчим хүчний төвлөрсөн эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлж, найдвартай ажиллагааг ханган гэр хорооллын өрхийг 2.5кВт хүчин чадалтай цахилгаан халаагуураар халаах техникийн нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

7.10. Нийтийн эзэмшлийн гудамж талбай, гэр хорооллын гудамжуудыг камержуулж, 100 хувь гэрэлтүүлэгтэй болгоно


7.11. Агаарын чанарыг сайжруулж бүсийн өрхүүдийг сайжруулсан түлшээр хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

7.12. Дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах сайжруулсан шахмал түлшний бутлуурын цехийг газар доорх байгууламжинд байрлуулж, орчны бохирдол тоос тоосонцорыг бүрэн арилгана.

7.13. Угсармал орон сууцны болон сургууль, цэцэрлэгийн дулаан алдагдлыг бууруулах төслийг хэрэгжүүлнэ.

7.14. Иргэдэд гэр, байшин, дулаалга хийх, оршин суугчдыг мэдээллээр хангаж ажиллана

7.15. Нийтийн тээврийн үйлчилгээний стандартад нийцсэн зогсоол, нийтийн ариун цэврийн байгууламж, тэмдэг, тэмдэглэгээ, тэдгээрийн арчлалт хамгаалалтыг бий болгоно.



7.16. Шинэ суурьшлын болон төвөөс алслагдсан бүсэд нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийг нэмэгдүүлнэ.

7.17. Такси үйлчилгээг орчин үеийн шаардлагад нийцсэн, аюулгүй, хүртээмжтэй болгоход хувийн хэвшилтэй хамтарч ажиллана.

7.18. Саппоро, Таван шар, 21 дүгээр хорооллын уулзварууд, Хархорин захын орчимд нүхэн болон гүүрэн гарц байгуулна.

7.19. Дүүргийн гэр хорооллын гудамжны 50 хувийг иргэдийн оролцоотойгоор хатуу хучилттай авто замтай болгож, Драгон төвийг Яармагтай, Баянхошууг Өнөр хороололтой, Авто худалдааны төвийг Тахилттай, Хүнс трейдийг Өнчин цагаантай холбох авто замуудыг шинээр барина.

7.20. Саппорогийн уулзварыг олон огтлолцолтой болгож Цэргийн хотхоноос Найрамдал хүртэлх замыг 4 урсгалтай болгож шинэчилнэ.

### **ЗОРИЛТ 8. АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛНА**

***Нэг хүнд ногдох ногоон байгууламжийг нэмэгдүүлэн ойн зурвас, ногоон төгөл, цэцэрлэгт хүрээлэнг барьж байгуулан явган хүний болон дугуйн замыг бий болгоно. Хог хаягдлыг ялгаж дахин боловсруулдаг болгоно.***

Зорилт 8-г хангахын тулд доорх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

8.1. Гэр хорооллын дундах тохижилтыг жишиг загвараар хийж, оршин суугчдыг гудамж, орчноо тохижуулах ажлыг зохион байгуулна

8.2. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн сул шороон хөрсийг хатуу хучилттай болгож, ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, байгууллага, иргэдийн оролцоотойгоор арчлалт хамгаалалтыг зохион байгуулна.


8.3. Баянхошуу уул, Сонгинохайрхан уулын бэл, Улаанчулуут, Монгол наадам цогцолбор орчимд ойн зурвас, ногоон төгөл, цэцэрлэгт хүрээлэн байгуулж, амралт зугаалгын бүс болгож хөгжүүлнэ.

8.4. Ногоон байгууламжийн усалгаанд борооны ус, гадаргын ус цуглуулж, авто замын болон үйлдвэр, аж ахуйн нэгжийн бохирдолтой усыг дахин цэвэршүүлж ашиглах ажлыг зохион байгуулна.

8.5. Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн дотоод агаарын чанарыг сайжруулах арга хэмжээг төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хандивлагч Олон Улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

8.6. Орчны тохижилтод иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлж, хөрөнгийн арчлалт, хамгаалалттай холбоотой урсгал зардлыг төсөвт тусгаж хэрэгжүүлнэ.

8.7. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлж, экосистемийг хадгалан хамгаалах, доройтсон ой, хөрсийг нөхөн сэргээх, моджуулах ажлыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоотой хэрэгжүүлнэ.



8.8. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, олборлолтыг суурьшлын бүсэд хязгаарлан, биологийн нөхөн сэргээлтийг хийлгэнэ.

8.9. Хог хаягдлыг багасгах, боловсруулах дахин ашиглах санаачилгыг дэмжин, ахуйн хог хаягдлыг ангилан ялгах, тээвэрлэх бага оврын дундын байгууламж барьж, тээвэрлэгч байгууллагыг зориулалтын машин механизмаар хангаж хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

8.10. Эмээлтэд малын гаралтай хог хаягдлыг ачиж цуглуулах, тээвэрлэх, ангилан ялгах, дахин боловсруулах, устгах систем нэвтрүүлнэ.

8.11. Нарангийн энгэр дэх төвлөрсөн хогийн цэгийг хааж, хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагааг дэмжин эко парк байгуулна.

### **ЗОРИЛТ 9. УНДНЫ УС, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙГ САЙЖРУУЛНА**

*Гэр хорооллын оршин суугчдыг баталгаат ундны усны эх үүсвэрээр бүрэн хангаж уламжлалт нүхэн жорлонгоос татгалзаж, сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгоно.*

Зорилт 9-ийг хангахын тулд доорх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

9.1. Гэр хорооллын 10,000 айл өрхүүдийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах ажлыг зохион байгуулна.

9.2. Гэр хорооллын иргэдийн усны хангамжийг сайжруулах ухаалаг худаг төслийг хэрэгжүүлж, иргэдийг 24 цагийн турш ундны усаар хангана.

9.3. Ундны усны хүртээмж бага алслагдсан байршилд шинээр усан санг барьж байгуулна.


### **ЗОРИЛТ 10. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛНА**

*Дүүргийн төрийн албан хаагчдыг авлигаас ангид, мэргэшсэн, ур чадвартай, тогтвортой ажиллах, хүний нөөцийг бүрдүүлснээр шатлан дэвшүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэж, төрийн албаны стандарт, мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.*

Зорилт 10-ыг хангахын тулд доорх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:


10.1. Дүүргийн нутгийн удирдлагын төв байр, хороодын цогцолбор барьж, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг нэг дор төвлөрүүлэн, чирэгдэлгүй, хөнгөн шуурхай, хүртээмжтэй болгоно

10.2. Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, иргэдэд чирэгдэлгүй, ялгаваргүй, тэгш, шударгаар үйлчлэх эрх зүйн орчинг цогцоор нь бүрдүүлнэ.



11.6. Эрчимжсэн фермерийн аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, малын үүлдэр угсааг сайжруулж, мал амьтны эрүүл мэндийг хамгаалах, малын гоц халдварт, халдварт, паразиттах өвчинтэй тэмцэх, урьчилан сэргийлэх эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

11.7. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин усалгаатай болон хамгаалагдсан хөрсний аж ахуйг хөгжүүлэх, орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, зoorь, агуулахын багтаамжийг нэмэгдүүлэх замаар төмс, хүнсний ногооны хэрэгцээг хангах.





**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.07.09 № 1216  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ХАН-УУЛ  
ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН  
НАМЫН ХОРООНД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Хан-Уул дүүргийн Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Хан-Уул дүүргийн Монгол Ардын намын хорооны Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн


37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хан-Уул дүүргийн Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Хан-Уул дүүргийн сонгуулийн хороонд

Хавсралт: 5... хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НОМИНБААТАР



Нийслэлийн Хан-Уул дүүргийн Монгол Ардын  
намын хорооны 2020 оны 06 дугаар сарын  
23-ны өдрийн II хуралдааны 01 дүгээр  
тогтоолын хавсралт

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН  
НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

НЭГ. ЭКО ДҮҮРЭГ – НОГООН ХӨГЖИЛ  
ХОЁР. ЭРҮҮЛ ДҮҮРЭГ – ХҮНИЙ ХӨГЖИЛ  
ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ – ИРГЭН БҮРТ  
ДӨРӨВ. НИЙГМИЙН ХӨГЖИЛ - ӨРХ БҮРТ  
ТАВ. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ - ХОРОО БҮРТ

**НЭГ. ЭКО ДҮҮРЭГ – НОГООН ХӨГЖИЛ**

- 1.1 **Дүүргийн тохижилт** - Архитекторийн шинэ шийдэл бүхий нэгдсэн бодлогоор хангаж ажиллана.
- 1.2 **Цэцэрлэгт хүрээлэн хөтөлбөр** - Иргэдийн амралт чөлөөт цагаа өнгөрөөх, аялал жуулчлалыг нэмэгдүүлэх зорилго бүхий бичил цэцэрлэгт хүрээлэн хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.
- 1.3 **Байгаль орчины хяналт** – Байгаль орчин, эрүүп мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгалийн нөөцийн хууль бус ашиглалт, нөхөн сэргээлтэд тавих хяналтыг сайжруулах хариуцлагыг дээшлүүлнэ.
- 1.4 **Иргэдийн Экологийн боловсрол** - Иргэдэд экологийн боловсрол олгож, амьдралын зөв дадлыг төлөвшүүлнэ.
- 1.5 **Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх** - Дүүргийн хэмжээнд ногоон байгууламжийн хэмжээг 10 дахин нэмэгдүүлж, арчилгааг орх бүрт урамшуулалттай хариуцуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.6 **Эко зурвас дэд хөтөлбөр** - Богд уул, Туул, Дунд голын дагуух дүүргийн нутаг дэвсгэрт амралт, үйлчилгээний эко зурвасуудыг байгуулах ажлыг үлгэлжлүүлж соёл урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.7 **Дотоодын аялал, жуучлал** - Дотоодын аялалыг хөгжүүлэхэд анхаарч хүйтний улиралд иргэд олон нийт амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх өвлийн баазыг Яармаг, Сонгино, Жаргалантын аманд байгуулж мөн соёлын өвүүдийг түшиглэн “Их түүхийн жимээр” аялалын маршрутыг бий болгоно.

**ХОЁР. ЭРҮҮЛ ДҮҮРЭГ – ХҮНИЙ ХӨГЖИЛ**

- 2.1 **Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх хөтөлбөр** - Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх тал дээр төрийн бус байгууллага болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, Хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор фитнэс болон спорт клубуудыг



бодлогоор дэмжиж, “Нийтийн гүйлт”, “Богд хаан хайрханы уулын алхалт”, “Өдөр бүр 5 км явган алхалт”, “Дугуйтай Хан-Уул”, “Эрүүл мэндийн бүжиг” хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ.

- 2.2 **Хотын соёл аян** – Бүх шатны боловсрол, соёлын байгууллагууд болон олон нийтийн сүлжээг ашиглан соёлын боловсрол олгох “Хотын соёл” олон нийтийн аян өрнүүлнэ.
- 2.3 **Спортын өсвөр үе, залуучуудын шигшээ баг хөтөлбөр** – Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөр үе, залуучуудын шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлж, Дүүргийн иргэдийн спортын наадмыг олон төрлөөр жил бүр өргөн хүрээнд зохион байгуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.4 **Цахим эмч үйлчилгээг нэвтрүүлэх** - Иргэдийг чихрийн шижин, цусны даралт ихсэх, хорт хавдар зэрэг зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт жилд нэг удаа үнэ төлбөргүй хамруулах, өвчнийг хянах цогц арга хэмжээ, цахим эмч онлайн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 2.5 **“Сүрьеэгүй Хан-Уул” хөтөлбөр** - Сүрьеэгийн идэвхтэй эрт илрүүлгийг сайжруулж, ертөмтгий бүлгийн иргэдийн судалгааг гарган урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд жилд 1 удаа оруулж эмчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлэн өвчлөлийн төвшинг бууруулах арга хэмжээ авч ажиллана.
- 2.6 **Хорт зуршилаас урьдчилан сэргийлэх хөтөлбөр** - Иргэд, өсвөр үе, залуучуудыг архи, тамхи, мансууруулах төрлийн бодис хэрэглэх хорт зуршилаас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.7 **Харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр** - Харшлын өвчин үүсгэгч ургамлыг устгах, тоосонцрын дэгдэлтийг бууруулах “Шарилжгүй эрүүл дүүрэг”, “Харшилгүй Эко дүүрэг”, “Тоосгүй Эко дүүрэг”, “Эрүүл дүүрэг Эко дүүрэг” гэсэн хөтөлбөрүүдийг жил бүр тогтмол хэрэгжүүлнэ.

## ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ – ИРГЭН БҮРТ

- 3.1 **Монголын хөгжил хүүхдээс хөтөлбөр** - Зөв хүүхэд зөв ирээдүй хөтөлбөрийн үргэлжлэл “Монголын хөгжил хүүхдээс” хөтөлбөрийг хэрэгжүүлэн, “Хүүхдийн авьяас төв”-ийг таваас доошгүйг байгуулна.
- 3.2 **Хөгжлийн төвүүд хөтөлбөр** - “Ахмад настан” болон “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд”-ийн болон бусад хөгжлийн төв барих ажлыг үргэлжлүүлнэ.
- 3.3 **Ахмаддаа дээдлэе хөтөлбөр** - Ахмаддууд өөрсдийн мэдлэг туршлагаа залуу үетэйгээ хуваалцах боломжийг хангах үүднээс “Ахмад үеэсээ суралцъя” төсөлт арга хэмжээ, ахмадуудад зориулсан үйлчилгээний жишиг стандартыг дүүргийн төр захиргааны байгууллагуудаас эхлэн нэвтрүүлнэ.
- 3.4 **Тусч найзууд хөтөлбөр** - Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, тэдний асран хамгаалагч болон залуу ээж зориулсан “Тусч найзууд” бүлгэмийг хороо бүрт зохион байгуулж ажиллуулна.
- 3.5 **Хүүхэд хамгааллын хяналт хөтөлбөр** - Хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээлэл хяналтын тогтолцоог бэхжүүлж, хүүхдийн асрамж, халамжийн



төвүүдэд гэр бүлийн хувилбарт үйлчилгээг нэвтрүүлэх замаар хараа хяналтгүй, хөдөлмөр эрхэлдэг, хүчирхийлэлд өртсөн, эрх нь зөрчигдсөн хүүхдийн тоог бууруулна.

- 3.6 **Иргэдийн оролцоо цахим хөтөлбөр** - Төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангаж, иргэдийн гомдол санал хүсэлтийг шийдвэрлэх цахим бүртгэлийн системийг бий болгож шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зориолготой цахим технологийг нэвтрүүлнэ.
- 3.7 **Гадаад байгаа иргэдэд төрийн үйлчилгээ** - Гадаадад ажиллаж амьдардаг иргэдэд дүүргийн төрийн үйлчилгээг цахимаар үзүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 3.8 **“Олон нийтийн цагдаа”, “Оюутан цагдаа” хөтөлбөр** - Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулж, цагийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, хамтран ажиллах замаар “Олон нийтийн цагдаа”, “Оюутан цагдаа” арга хэмжээг үргэлжлүүлнэ.

### ДӨРӨВ. НИЙГМИЙН ХӨГЖИЛ - ӨРХ БҮРТ

- 4.1 **Гэр бүлийг дэмжих хөтөлбөр** - Гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бий болгох зорилгоор сар бүр “Гэр бүлийн өдөр”-ийг тэмдэглэн хэвшүүлж гэр бүлд чиглэсэн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж “Гэр бүлд ээлтэй” үйлчилгээний байгууллагыг шалгаруулан олон нийтэд сурталчилна.
- 4.2 **Гэр хорооллын ариун цэврийн өрөө хөтөлбөр** - Гэр хорооллын ариун цэврийн шаардлага хангахгүй жорлонг шинэ технолагийн шийдлээр өөрчлөх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 4.3 **Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих** - Орчин үеийн дэвшилтэт технологи бүхий бага, дунд оврын жишиг загвар бүхий үйлдвэр байгуулахыг дэмжинэ.
- 4.4 **Цахим худалдаа хөтөлбөр** - Дүүргийн иргэд, өрхийн бизнесийг дэмжих зорилгоор интернэт худалдааны платформыг бий болгоно.
- 4.5 **Эко зуслангийн хотхон** - Төр хувийн хэвшлийн хамтарсан түншилээр залуу гэр бүлд зориулсан Эко зуслангийн хотхон, зуслангийн түрээсийн байр хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 4.6 **24 цагийн үйлчилгээт цэцэрлэг** - Дүүргийн хэмжээнд шинээр 24 цагийн үйлчилгээтэй цэцэрлэг 2-оос доошгүйг нэмэгдүүлнэ.
- 4.7 **Цахим хяналт** - Сургууль, эцэг эх, сурагчдын хооронд мэдээлэл солилцох, сурагчийн аюулгүй байдалд хяналт тавих цахим системийг хэрэгжүүлнэ.
- 4.8 **Камержуулалт хүүхдэд** - Сургууль цэцэрлэг, хүүхдийн тоглоомын талбайн камержуулалтыг сайжруулна.
- 4.9 **Цахим номын сан хөтөлбөр** - Сургуулиудад цахим номын сан байгуулах, бусад гадаадын болон дотоодын номын сангуудын цахим сантай холбож, сурагч солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.





37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Чингэлтэй дүүргийн Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Чингэлтэй дүүргийн сонгуулийн хороонд

Хавсралт: 5... хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НОМИНБААТАР



Чингэлтэй дүүргийн Монгол Ардын Намын хорооны  
III хуралдаан 2020 оны 6 дугаар сарын 23-ны  
өдрийн 9 тогтоолын 4 хавсралт



## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН НАМААС 2020 ОНЫ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХОТӨЛБӨР

### ЭРХЭМ СОНГОГЧ ТАНАА

Чингэлтэй дүүргийн Монгол Ардын Намаас дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны сонгуульд оролцох, “ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ, ЦЭМЦГЭР, БҮТЭЭГЧ, ИРГЭНЛЭГ ДҮҮРГИЙН ТӨЛӨӨ ХҮЧЭЭ НЭГТГЭЭ” үндсэн уриатай мөрийн хөтөлбөрөө Та бүхэнд толилуулж байна.

Мөрийн хөтөлбөрөөрөөр хэрэгжүүлэх Чингэлтэй дүүргийн МАН-ын хорооны үйл ажиллагааны бодлого, зорилтууд

- Эрүүл, спортлог дүүрэг;
- Хүн төвтэй дүүрэг;
- Соёлтой, цэвэр дүүрэг;
- Бүтээн байгуулагч дүүрэг;
- Сайн засаглалтай, иргэнлэг дүүрэг гэсэн таван үндсэн хэсэгтэй.

### НЭГ. ЭРҮҮЛ, СПОРТЛОГ ДҮҮРЭГ

Байгальд ээлтэй шинэ технологи, бараа бүтээгдэхүүн, шинэлэг санал, санаачилгыг нэвтрүүлж, иргэд нь эрүүл чийрэг, хүрээлэн буй орчны стандартыг бүрдүүлж цэвэр цэмцгэр, ногоон хөгжилд суурилсан цэцэрлэгт хүрээлэн бүхий эко дүүргийг Чингэлтэйд бий болгоно.

“Эрүүл Чингэлтэйчүүд” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн хүрээнд Чингэлтэй хайрхан болон бусад чиглэлд “Аялал жуулчлалын 10 маршрут” бий болгож, үйл ажиллагааг нь жигдрүүлнэ.

“Спортлог Чингэлтэй”, “Чингэлтэй лиг” зэрэг дэд хөтөлбөрүүд боловсруулж, Улаанбаатар хотдоо мэргэжлийн спорт, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэн, хүн амын бие бялдарыг чийрэгжүүлэх олон төрөлт уралдаан тэмцээн зохион байгуулна.

Спорт цогцолборуудыг үе шаттайгаар байгуулан, ашиглалт үйл ажиллагааг нь тогтмолжуулна.

“Дүүргийн Нэгдсэн эмнэлэг”, “Хороод дундын орхийн эрүүл мэндийн жишиг төв”-үүдийг шинээр барьж байгуулна. Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг шинэ хэлбэрт шилжүүлж, иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна.



Олон улсын стандартад нийцсэн ахмадын асрамжийн газар, байнгын асаргаа шаардсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгчдийн асрамжийн төв, ахмадын ооол, орүүл мөндийн тов шинээр байгуулна.

Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулна. Халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулах, зорилт бүлгийн иргэдэд чиглэсэн нийгмийн үйлчилгээний шинэ хэлбэрийг бий болгоно.

### **ХОЁР. ХҮН ТӨВТЭЙ ДҮҮРЭГ**

“Жаргалтай үрс” төслийг үргэлжлүүлэн Хүүхдийн аюулгүй байдлыг хангах шинэ бодлого, тогтолцоог бүрдүүлж хүүхдийг гэмтэл ослоос урьдчилан сэргийлэх журам, дүрмийг амьдралд нийцүүлэн шинэчлэн гаргаж, нэвтрүүлнэ.

Дүүргийн газар нутагт баригдсан, шинээр баригдах хүүхдэд зориулсан тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн бусад спорт, чөлөөт цагийн цогцолборуудад “Хүүхдэд учирч болох аюул ослоос урьдчилан сэргийлсэн эрсдэлийн үнэлгээ, тооцоо”-г мэргэжлийн байгууллагуудаар гаргуулж, хүүхдийн аюулгүй байдлыг хангах тэмдэг, тэмдэглэгээг шинээр тавих жишиг ажлуудыг эхлүүлнэ.

Хүүхдүүдэд аюулыг үнэлэх чадвар суулгах, сурч боловсрох, хөгжих орчны аюулгүй байдлын мэдлэг олгох, ахуйн ослоос хүүхдийг хамгаалах, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга барилд сургах “дадлага сургалт” явуулах мэргэжлийн багш нарыг тусгайлан бэлтгэх ажлыг эхлүүлнэ. Ингэснээр Монгол хүүхдийн аюулгүй байдлыг уламжлалт хандлага дээр үндэслэн орчин үеийн хот суурин, өндөр технологитой нийцүүлэх арга барилд хүүхдүүдийг сургах ажлын эхлэл Чингэлтэй дүүрэгт анхлан тавигдана.

Иргэдийг эрүүл, аюулгүй хүнсээр хангах зорилтын хүрээнд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг идэвхжүүлж, үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, худалдаа үйлчилгээний салбаруудад тавигдах стандартын хэрэгжилтийг ахисан түвшинд хүргэнэ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог “Гудамжны эргүүл” хэлбэрээр нэмэгдүүлж, дэг журам сахиулах, гэмт хэргийн гаралтыг бууруулахад чиглэсэн эрх зүйн орчинг сайжруулж, эргүүл хяналтын үйл ажиллагааг тогтмолжуулна.

Гэрэлтүүлэг, камержуулалттай нэгдсэн удирдлага-хяналтын систем бүхий “Жишиг гудамж”-уудын тоог гэр хороололд олшруулна.

Явган зорчигчийн аюулгүй байдлыг хангасан замуудыг шинээр барьж байгуулна.

Гэр хорооллын цахилгааны хэрэглэгчдийн аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийлгэж, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг нэг бүрчлэн авна. Түүнчлэн цахилгаанаас үүдэлтэй ахуйн ослыг тоог бууруулах үндэс суурийг дүүрогтоо бий болгоно.

### **ГУРАВ. СОЁЛТОЙ, ЦЭВЭР ДҮҮРЭГ**

Хотын гудамж талбай, орон сууц, гэр хорооллын дунд олон улсын стандартад нийцсэн хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж барьж, хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх таатай орчныг бүрдүүлнэ..



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд оролцох боломжийг бүрдүүлэхэд анхаарч дэд бүтэц, тохижилт, барилга байгууламж, зам талбайн стандартыг хангуулна.

Гэр хорооллын айлуудын нүхэн жорлонгийн лагийг цэвэрлэх-цуглуулах шинэ стандартыг бий болгож, хүн-байгальд хоргүйгээр устгах эко технологи, менежментийн цогц бодлогыг хэрэгжүүлж, энэ ажилд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

Гэр хорооллын айл өрхүүдийг үнс түр хадгалах зориулалтын савтай болгох ажлыг эхлүүлж, үнс дахин боловсруулах үйлдвэртэй холбосон тээврийн үйлчилгээг шинээр бий болгоно.

Хог хаягдлын менежментийг сайжруулж, тээвэрлэх, ангилах, боловсруулах, худалдан авах цогц менежментийг бий болгоно. Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эхлүүлнэ.

Хотын төвөөс алслагдсан бүсийн иргэдэд халуун ус, үсчин, гоо сайхан, хими цэвэрлэгээний цогц үйлчилгээ үзүүлэх ахуйн үйлчилгээний төвүүдийн тоог нэмэгдүүлнэ.

Хотын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн гудамж, талбайн нэр, байшин барилгын хаягийн нэгдсэн стандартыг мөрдүүлж ажиллана.

Жуулчлалд зориулсан бүс байгуулж, Чингэлтэй хайрханыг чиглэсэн аялалыг өвөл, зуны чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлж, амрах үдлэх тохижсон цэгүүдийг шинээр бий болгоно.

## **ДӨРӨВ. БҮТЭЭН БАЙГУУЛАГЧ ДҮҮРЭГ**

Дүүргийн тор захиргааны байрыг Улаанбаатар хотын төвлөрлөөс гаргаж гэр хороолол дунд шинээр барьж байгуулна.

Гэр хорооллын болон хотын төвийн хуучин барилгуудын дахин төлөвлөлтийн ажлыг эрчимжүүлнэ.

Зуслан, гэр хорооллын зам, замын байгууламжийн төлөвлөлтийг оновчтой болгож, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний шинэчлэлтийн ажлыг эрчимжүүлж, асфальт, бетонон болон байгалийн чулуун замуудаар гэр хорооллын гол гудамжуудыг төв замтай холбож, олон чиглэлтэй бөглөрөлгүй зам харилцааг хөгжүүлэн тоосжилтыг бууруулна.

Төрийн албан хаагчиддаа зориулсан олон төрлийн (орлогод нийцсэн, амины, түрээсийн, ногоон) инженерийн шийдэл бүхий орон сууц барих хөтөлбөрийг боловсруулж, дүүрэг бие дааж хэрэгжүүлнэ.

Орон сууцны хороодын дунд “Хайрхан хөгжил төв - IV”-ийг шинээр барьж байгуулна.

“Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд “Дэнжийн мянга”, “Сэлбэ дэд төв”-үүдийн үйл ажиллагааг эхлүүлж, орон сууцны хороолол барих ажлыг улс, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар зохион байгуулна. Гэр хорооллуудын дунд “Дэд бүтцийн төв” (“Сурбио центр”) нэмж байгуулна.



Өмчилсөн газартаа дулаан, цэвэр, бохир усны системтэй, ажлын байртай, тохилог амины орон сууц барих төсөл хөтөлбөрийг бүхий л талаар дэмжиж “Түрээсийн орон сууц”-ыг нэмэгдүүлэх арга хэмжээг авна.

Хороодыг хотын төвтэй холбосон дугуйн замын шинэ маршрутуудыг дүүргийн нутаг дэвсгэртээ бий болгож, стандартын дагуу хийгдсэн тохижилт, гэрэлтүүлэг, зогсоолтой дугуйн замын уртын хэмжээг 100 дахин нэмэгдүүлж, иргэд тав тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.

Дүүргийн нутаг дэвсгэрт тохилог орон сууц, амины орон сууц барих төсөл хэрэгжүүлэгчдийг дэмжин ажиллаж, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнд холбогдсон тохилог сууцуудыг бий болгоход анхаарна.

### **ТАВ. САЙН ЗАСАГЛАЛТАЙ, ИРГЭНЛЭГ ДҮҮРЭГ**

Боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, биеийн тамир спорт, ахуйн үйлчилгээ, төрийн үйлчилгээг иргэдэд таатай хэлбэрээр бүрдүүлж, хөгжүүлнэ.

Төрийн албаны үйл ажиллагааны хяналт, хариуцлагын тогтолцоог шинэ шатанд гаргана. Төрийн албаны хүнд сурталыг байхгүй болгох шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Төрийн албан хаагчдын ажлын үр дүнг тооцох систем, хүний нөөцийн бодлогыг оновчтой болгож, төрийн албаны үйл ажиллагаа шуурхай, ил тод, иргэдэд ойрхон байх нөхцөлийг бүрдүүлнэ.

Иргэн төвтэй төрийн үйлчилгээг жишиг хэлбэрээр шинэчилж, нэг цэгийн үйлчилгээний чанарыг сайжруулна.

Баялаг бүтээгч иргэдийг дэмжин, үйлдвэрлэл, үйлчилгээнд шинэ техник технологи, инновацыг нэвтрүүлнэ.

Иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлж, хөдөлмөрийн насны иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулна.

Ядуурлыг бууруулах, амьдралын чанарыг сайжруулах зорилго бүхий хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн зорилтод бүлгийн 500 өрхийг ахисан түвшинд хүргэнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах, нийгэмд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх үр өгөөжтэй бодлого боловсруулан, олон улсын байгууллагуудтай хамтран үр дүнд хүргэж ажиллана.

Нийгмийн эрүүл мэндийг сайжруулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанаржуулахад чиглэсэн иргэний бүртгэл мэдээллийн технологийг боловсронгуй болгоно.

Залуусын хөгжлийг бүх талаар дэмжсэн олон талын арга хэмжээг зохион байгуулах “Хөгжлийн ордон”-ыг шинээр барьж үйл ажиллагааг жигдрүүлнэ.



Улсын болон хувийн, олон улсын төслийн хөрөнгө оруулалт татаж, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын барилга байгууламжийг өргөтгөх, шинээр барьж байгуулах замаар анги дүүргэлтийг стандартын түвшинд хүргэнэ.

Олон улсын сургалтын хөтөлбөртэй Ерөнхий боловсролын сургуулиудын тоог нэмэгдүүлж, боловсролын салбарын хүртээмж, чанарыг дээшлүүлнэ.

Хайлааст чиглэлийн Ерөнхий боловсролын 17, 49, 72 дугаар сургуулиудын дунд "Гадаад хэлний сургалтын төв"-ийг орчин үеийн стандарт, шаардлагад нийцүүлэн байгуулж, гадаадад тэтгэлэгээр суралцах Чингэлтэйн хүүхдүүдийн тоог нэмэгдүүлнэ.

Хууль бус газар олголт, нийтийн эрх ашигт үл нийцсэн шийдвэрүүдийг цуцлана.

Иргэдийн газар эзэмших, өмчлөх болон газраа эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачилгыг дэмжин, газрын харилцаатай холбоотой мэдээлэл нээлттэй, ил тод байх тогтолцоог бий болгоно.

Газраа барьцаалан амины орон сууц барих иргэдийг ипотекийн зээлд хамруулах ажлыг зөв жишгээр зохион байгуулна.

Шинээр жижиг дунд бизнес эхлүүлэх иргэдэд эхний үе шатны хүндрэлийг даван туулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулж, цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулах, зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулах төсөл хөтөлбөрүүдэд хамруулна.

Хүүхэд залуучуудад эх оронч үзэл, ёс зүй, ухамсар төлөвшүүлэхэд бүх байгууллага нэгжийн оролцоог бий болгож, үйл ажиллагааг нь уялдуулна.

Цэргийн албыг биеэр болон хуульд заасан бусад хэлбэрээр хаах иргэдийн хүсэл сонирхол, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авна.

Томилгоот албан тушаалтнуудад аюулгүй байдал, батлан хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай цэргийн хэргийн мэдлэг, дадлага олгох цэрэг-стратегийн бэлтгэл сургалтыг Үндэсний батлан хамгаалахын их сургуультай хамтран зохион байгуулна.

## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

